

Гарчиг

НЭГ. ОРШИЛ	9
1.1. <u>Төслийн товч танилцуулга</u>	10
1.2. <u>Бүс нутгийн хөгжлийн чиг хандлага, бодлого</u>	10
ХОЁР. ГЕОЛОГИ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ НӨХЦӨЛ.....	14
2.1. <u>Сумын нутаг дэвсгэрийн байршил, тогтоц</u>	14
2.1.1. Газар зүйн байрлал.	14
2.1.2. Сумын хилийн цэс	15
2.1.3. Багийн хилийн цэс	17
2.1.4. Газрын гадарга.	20
2.1.5. Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн мужлал.	22
2.1.6. Гадаргын налуу	23
2.1.7. Гадаргын зүг зовхис.	25
2.2. <u>Сумын уур амьсгал</u>	27
2.2.1. Агаарын температур.	27
2.2.2. Хур тунадас.	30
2.3. <u>Хөрс, хөрсөн бүрхэвч</u>	32
2.3.1. Хөрс үүсгэгч чулуулаг.	32
2.3.2. Хөрсний хэв шинж.	35
2.3.3. Сумын хөрсний механик бүрэлдэхүүн.	39
2.4. <u>Ургамалжилт</u>	41
2.4.1. Сумын ургамлын экологийн хэв шинж.	41
2.4.2. Сумын бэлчээрийн ургамалжилт, төрөл	43
2.4.3. Сумын бэлчээрийн ургамалжилтийн төрх байдал, төлөв.	47
2.4.4. Бэлчээрийн төлөв байдал	49
2.5. <u>Ойн нөөц, төлөв байдал</u>	51
2.5.1. Сумын ойн нөөц.....	51
2.5.2. Ойн төлөв байдал.....	53
2.6. <u>Гадаргын болон гүний усны нөөц</u>	55
2.6.1. Гадаргын усны нөөц.	55
2.6.2. Гүний усны нөөц.....	59
2.7. <u>Инженер геологийн нөхцөл</u>	61
2.7.1. Геологийн мужлал.	61
2.7.2. Геоморфологийн тогтоц.....	64
2.7.3. Цэвдгийн нөхцөл	66
2.7.4. Газар чичирхийлэл	68
ГУРАВ. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ.....	69
3.1. <u>Түүхэн хөгжлийн тойм</u>	69
3.2. <u>Хүн ам зүй</u>	70
3.2.1. Хүн амын тоо ба өрхийн байдал.....	70
3.2.2. Хүн амын амьжиргааны түвшин ба орлого.....	71
3.3. <u>Хөдөө аж ахуйн салбар</u>	74
3.3.1. Мал аж ахуйн салбар.....	74

3.3.2.	Малчин өрхийн малын тоо ба соёл ахуйн зарим үзүүлэлт	79
3.3.3.	Газар тариалан	80
3.4.	<u>Аж ахуй нэгж</u>	82
3.6.	<u>Банк санхүү</u>	83
3.6.1.	Эрүүл мэнд	84
3.6.2.	Боловсрол	85
ДӨРӨВ. ГАЗАР, БАЙГАЛИЙН НӨӨЦ ЭДЭЛБЭРИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ		87
4.1.	<u>Газрын нэгдмэл сан</u>	87
4.2.	<u>Сумын газар ашиглалтын одоогийн байдал</u>	89
4.2.1.	Бэлчээр ашиглалт.....	92
4.2.2.	Тариалангийн газрын ашиглалт	98
4.2.3.	Ойн сан бүхий газрын ашиглалт	101
4.2.4.	Уул уурхайн ашиглалт	102
4.2.5.	Аялал жуулчлалын газрын ашиглалт.....	104
4.2.6.	Тусгай хамгаалалттай газар.....	108
4.3.	<u>Газар болон байгалийн нөөц</u>	110
4.3.1.	Бэлчээрийн газрын экологийн чадавхийн үнэлгээ	110
	<u>Бэлчээрийн газрын экологийн чадавхийн үнэлгээ</u>	112
4.3.2.	Бэлчээрийн газрын эдийн засгийн үнэлгээ тооцох арга зүй.....	117
	<i>Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээ, бэлчээрийн багтаамжийг тооцох</i>	117
	<u>Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох /Хонин сүрэг/</u>	118
	<u>Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох /Ямаан сүрэг/</u>	120
4.3.3.	Түүх соёлын дурсгалт газар.....	124
4.3.4.	Амьтны тархалт	129
4.3.5.	Ховор ургамлын тархалт.....	131
4.4.	<u>Сумын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ</u>	132
4.4.1.	Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ.....	132
4.4.2.	Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ.....	135
4.4.3.	Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ.....	138
4.4.4.	Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ.....	140
4.4.5.	Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ.....	153
4.4.6.	Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ.....	155
ТАВ. СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ		160
5.1.	<u>Иргэдийн оролцоотой ашиглалтын олон хэлбэр бүхий газрын хэрэгцээг байдлыг тогтоох</u>	160
5.2.	<u>Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө</u>	163
5.2.1.	Хамгаалалтын бүсийн төлөвлөгөө	167
5.2.2.	Бэлчээрийн газрын төлөвлөгөө	171
5.2.3.	Бэлчээр усжуулалт.....	174
5.2.4.	Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө.....	176
5.2.5.	Хадлангийн газрын төлөвлөгөө.....	186
5.2.6.	Ойн ашиглалт, хамгаалалтын бүс төлөвлөгөө	188
5.2.7.	Аялал жуулчлалын бүсийн төлөвлөгөө	190
5.2.8.	Авто замын газрын төлөвлөгөө	193
5.2.9.	Зүй ёсны эрхээр баталгаажуулах төлөвлөгөө.....	194

АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ	196
ХАВСРАЛТ.....	198

Зураг төслийн жагсаалт

Зураг-1. Газарзүйн байрлал	14
Зураг-2. Дэлгэрхаан сумын хилийн цэсийн зураг.....	16
Зураг-3. Багийн хилийн цэсийн зураг.	19
Зураг-4. Сумын газрын гадаргын өндөршилт.	21
Зураг-5. Сумын муж тойрог зураг.	22
Зураг-6. Гадаргын хэвгийн зураг.	24
Зураг-7. Зүг зовхисын зураг.	26
Зураг-8. Агаарын температур.	29
Зураг-9. Хур тунадас.....	31
Зураг-10. Хөрс үүсгэгч чулуулгийн зураг.	34
Зураг-11. Хөрсний тархалтын зураг.	38
Зураг-12. Хөрсний механик бүрэлдэхүүн.	40
Зураг-13. Ургамлын экологийн хэв шинжийн зураг.	42
Зураг-14. Ургамалжилтын зураг.	46
Зураг-15. Бэлчээрийн төрх байдлын зураг.	48
Зураг-16. Бэлчээрийн төлөв байдлын зураг.	50
Зураг-17. Ойн төрлийн зураг.	52
Зураг-18. Ойн төлөв байдлын зураг.....	54
Зураг-19. Хэрлэн голын ай сав.	57
Зураг-20. Гадаргын усны зураг.....	58
Зураг-21. Гидрогеологийн зураг.	60
Зураг-22. Геологийн зураг.	63
Зураг-23. Геоморфологийн зураг.....	65
Зураг-24. Цэвдгийн тархалтын зураг.	67
Зураг-25. Газар чичирхийллийн зураг.....	68
Зураг-26. Хүн ам зүйн зураг /Насны бүлгээр/.....	73
Зураг-27. Мал сүлгийн бүтэц.	78
Зураг-28. Газрын нэгдмэл сан.....	88
Зураг-29. Газар ашиглалтын зураг.	90
Зураг-30. Суурин газрын Кадастрын зураг	91
Зураг-31. Малчдын нутагладаг байршлын зураг.....	93
Зураг-32. Бэлчээрийн даац, багаар	96
Зураг-33. Бэлчээрийн даац, Отрын нөөц нутаг.	97
Зураг-34. Тариалангийн газрын зураг	100
Зураг-35. Ойн төрлийн зураг.	101
Зураг-36. Уул уурхайн газар ашиглалтын зураг	103
Зураг-37. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар	109
Зураг-38. Ургамлын экологийн хэв шинжийн зураг.	111
Зураг-38. Түүх соёлын дурсгалт газар	128
Зураг-39. Амьтны тархалт.....	130
Зураг-40. Ховор ургамал, жимс, жимсгэний тархалт.	131
Зураг-41. Тариалангийн тохиромжтой байдлын үнэлгээний зураг	134
Зураг-42. Аялал рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.....	137
Зураг-43. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.....	139
Зураг-44. Өвөл-Хаврын улиралд адуунд тохирох бэлчээрийн зураг.....	142
Зураг-45. Өвөл-Хаврын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг.....	143
Зураг-46. Өвөл-Хаврын улиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг.....	144
Зураг-47. Өвөл-Хаврын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг.....	145
Зураг-48. Өвөл-Хаврын улиралд хонинд тохирох бэлчээрийн зураг.....	146
Зураг-49. Зун-Намрын улиралд адуунд тохирох бэлчээрийн зураг.....	148
Зураг-50. Зун-Намрын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг.....	149
Зураг-51. Зун-Намрын улиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг.....	150
Зураг-52. Зун-Намрын улиралд хонинд тохирох бэлчээрийн зураг.....	151
Зураг-53. Зун-Намрын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг.....	152
Зураг-54. Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.....	154

Зураг-55. Авто зам болон төмөр замын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.	156
Зураг-56. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.	157
Зураг-57. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.	158
Зураг-58. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.	159
Зураг-59. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний зураг.	166
Зураг-60. Хамгаалалтын бүсүүдийн төлөвлөгөөний зураг.	168
Зураг-61. Улирлын бэлчээр ашиглалтын зураг.	173
Зураг-62. Усжуулах шаардлагатай бэлчээр.	175
Зураг-63. Бэлчээр ашиглалтын хэсгийн төлөвлөгөө зураг.	179
Зураг-64. Бэлчээр ашиглалтын хэсгийн даацын зураг.	185
Зураг-65. Хадлангийн газрын төлөвлөгөөний зураг.	187
Зураг-66. Ойн хамгаалалтын бүсийн зураг.	189
Зураг-67. Аялал жуулчлалын төлөвлөгөөний зураг.	192
Зураг-68. Авто замын төлөвлөгөөний зураг.	193
Зураг-69. Зүй ёсны эрхээр баталгаажуулах төлөвлөгөө.	195

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт-1. Сумын хилийн цэсийн солбилцол.....	15
Хүснэгт-2. Багуудын эзлэх газрын хэмжээ, эзлэх хувь.....	17
Хүснэгт-3. Багийн хилийн цэсийн эргэлтийн цэгүүд.....	18
Хүснэгт-4. Сумын гадаргын өндөржилтийн талбай.....	20
Хүснэгт-5. Сумын гадаргын өндөржилтийн талбай.....	23
Хүснэгт-6. Сумын гадаргын зүг зовхисын талбай.....	25
Хүснэгт-7. Сумын сарын дундаж агаарын температур.....	27
Хүснэгт-8. Сумын агаарын олон жилийн дундаж температур, °С.....	28
Хүснэгт-9. Хөрсний гадарга дээрх олон жилийн дундаж температур, °С.....	28
Хүснэгт-10. Сумын сарын хур тундас.....	30
Хүснэгт-11. Сумын хөрс үүсгэгч эх чулуулаг, талбай, хувь.....	32
Хүснэгт-12. Сумын хөрсний хэв шинж /талбай-га, %/.....	35
Хүснэгт-13. Сумын хөрсний механик бүрэлдэхүүн талбай, га.....	39
Хүснэгт-14. Сумын ургамалын экологийн хэв шинж.....	41
Хүснэгт-15. Сумын бэлчээрийн ургамалын анги.....	43
Хүснэгт-16. Сумын бэлчээрийн ургамалын төрөл зүйл.....	43
Хүснэгт-17. Сумын бэлчээрийн төрх байдал (талбай,%).....	47
Хүснэгт-18. Нөлөөлд өртсөн бэлчээрийн талбай.....	49
Хүснэгт-19. Сумын нутаг дэвсгэрт тархсан ойн төрөл.....	51
Хүснэгт-20. Ойн төлөв байдал /талбай, %/.....	53
Хүснэгт-21. Сумын уст цэгийн тоо.....	55
Хүснэгт-22. Сумын олон жилийн цэвдэгийн тархалт.....	66
Хүснэгт-23. Хүн ам, өрхийн тоо.....	70
Хүснэгт-24. Хүн амын нягтшил.....	70
Хүснэгт-25. Өрхийн байршил ба ам бүл.....	70
Хүснэгт-26. Хүн амын ердийн цэвэр өсөлт.....	70
Хүснэгт-27. Хүн амд хөдөлмөрийн насны хүмүүсийн эзлэх хувь.....	71
Хүснэгт-28. Эмзэг бүлгийн хүн амын тоо ба эзлэх хувь.....	71
Хүснэгт-29. Сумын өрхийн тоо, сууцны төрлөөр.....	71
Хүснэгт-30. Хадгаламжийн хэмжээ сая төг.....	71
Хүснэгт-31. Нийт зээлийн өрийн үлдэгдэл сая төг.....	72
Хүснэгт-32. Малын тооны өсөлт.....	74
Хүснэгт-33. Малын бүтэц ба өөрчлөлт.....	75
Хүснэгт-34. Сумын бойжуулсан төл.....	75
Хүснэгт-35. Зүй бусын хорогдлын тоо /мян,тоо/.....	76
Хүснэгт-36. Өвчнөөр хорогдсон малын тоо.....	77
Хүснэгт-37. Сум, багийн малын тоо.....	79
Хүснэгт-38. Малчин өрхөд оногдох малын тоо.....	79
Хүснэгт-39. Эрчим хүчний эх үүсвэр оролцогчдын хувиар.....	80
Хүснэгт-40. Малчин өрхийн ахуйн зарим үзүүлэлтүүд.....	80
Хүснэгт-41. Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан байдал.....	80
Хүснэгт-42. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тариалсан талбай /га/.....	80
Хүснэгт-43. 2014 онд хураан авсан ургацын хэмжээ.....	81
Хүснэгт-44. Аж ахуй нэгжийн өмчийн хэлбэр.....	82
Хүснэгт-45. Аж ахуй нэгжийн тоо.....	82
Хүснэгт-46. Хадгаламжийн хэмжээ сая төг.....	83
Хүснэгт-47. Нийт зээлийн өрийн үлдэгдэл сая төг.....	83
Хүснэгт-48. Эмнэлэгийн эмч, ажилчид.....	84
Хүснэгт-49. Халдварт өвчнөөр өвчилсөн тоо.....	85
Хүснэгт-50. Нэг сувилагчид ногдох хүний тоо.....	85
Хүснэгт-51. Цэцэрлэгийн судалгаа 5 жилээр.....	85
Хүснэгт-52. Сургуулийн судалгаа 5 жилээр.....	86
Хүснэгт-53. Сумын номын сан үзүүлэлт.....	86
Хүснэгт-54. Сумын газрын нэгдмэл сангийн ангилалын талбайн зөрүү.....	87
Хүснэгт-55. Сумын газар ашиглалтын талбай.....	89

Хүснэгт-56. Өвөлжөө, хаваржааны тоо.	92
Хүснэгт-57. Сумын бэлчээрийн даац, багаар.	94
Хүснэгт-58. Отрын бүсэд өвөлжсөн хонин толгой.	95
Хүснэгт-59. Сумын болон отрын бэлчээрийн даац.	95
Хүснэгт-60. Газар тариалангийн судалгаа.	98
Хүснэгт-61. Тариалангийн аж ахуй эрхлэгчдийн судалгаа.	99
Хүснэгт-62. Уул уурхайн газар ашиглалт.	102
Хүснэгт-63. Аялал жуулчлал амралт сувилалын үйлчилгээ үзүүлж байгаа иргэн аж ахуй нэгжийн судалгаа.	104
Хүснэгт-64. Улсын тусгай хамгаалалттай газрын ашиглалт.	108
Хүснэгт-65. Сумын тусгай хамгаалалттай газрын ашиглалт.	108
Хүснэгт-66. Бэлчээрийн ангилал.	110
Хүснэгт-67. Бэлчээрийн газрын жилийн нийт ургац(в)-ыг дараах хүснэгтээр тооцно.	117
Хүснэгт-68. Малын бэлчээрээс өдөрт идэх өвсний хэмжээ улирал тус бүрээр.	117
Хүснэгт-69. Нядалгааны гарц тооцох хүснэгт.	118
Хүснэгт-70. Монгол хонины махны гарц.	118
Хүснэгт-71. Хонин сүргийн зохистой харьцаа.	118
Хүснэгт-72. Хонины махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцож гаргавал дараах байдалтай байна.	118
Хүснэгт-73. Хонины сүү бий болгох чадавхийг дараах хүснэгтээр тооцно.	119
Хүснэгт-74. Хонины ноос бий болгох чадавхийг даарх хүснэгтээр тооцно.	119
Хүснэгт-75. Бэлчээрийн газрын газрын бүтээгч чадавхийг дараах хүснэгтээр тооцов.	120
Хүснэгт-76. Нядалгааны гарц тооцох хүснэгт.	121
Хүснэгт-77. Монгол ямааны махны гарц.	121
Хүснэгт-78. Ямаан сүргийн зохистой харьцаа.	121
Хүснэгт-79. Ямааны махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцож гаргавал дараах байдалтай байна.	121
Хүснэгт-80. Ямааны сүү бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцно.	122
Хүснэгт-81. Ямааны ноолуур бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцно.	123
Хүснэгт-82. Бэлчээрийн газрын газрын бүтээгч чадавхийг дараах хүснэгтээр тооцов.	123
Хүснэгт-83. Байгалийн үзэсгэлэнт газар.	124
Хүснэгт-84. Түүхийн дурсгалт газар.	126
Хүснэгт-85. Тариаланд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.	133
Хүснэгт-86. Аялал жуулчлалын газарт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.	136
Хүснэгт-87. Шинээр байгуулах хот, суурин газарт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.	138
Хүснэгт-88. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /Өвөл-Хавар/.	140
Хүснэгт-89. Таван хошуу малд тохиромжтой газрын хэмжээ, хувь /Өвөл-хавар/.	140
Хүснэгт-90. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /Зун-Намар/.	147
Хүснэгт-91. Таван хошуу малд тохиромжтой газрын хэмжээ, хувь /Зун-намар/.	147
Хүснэгт-92. Ой санд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.	153
Хүснэгт-93. Авто замд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.	155
Хүснэгт-94. Шугам сүлжээд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.	155
Хүснэгт-95. Иргэдээс авсан саналын судалгаа /4 иргэний жишээн дээр/.	161
Хүснэгт-96. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулахад хэрэглэгдэх заавар, стандартууд.	164
Хүснэгт-97. Сумын хамгаалалтын бүсүүдийн төлөвлөгөө.	167
Хүснэгт-98. Сумын хамгаалалтын бүсүүдийн талбайн хэмжээ.	169
Хүснэгт-99. Сумын улирлын бэлчээр ашиглалт, багаар.	172
Хүснэгт-100. Бэлчээр усжуулалтын судалгаа.	174
Хүснэгт-101. Бэлчээр ашиглалтын хэсгийн талбай.	176
Хүснэгт-102. Бэлчээр ашиглалтын хэсгийн багтаамж.	180
Хүснэгт-103. Бэлчээр ашиглалтын хэсгийн даац.	183
Хүснэгт-104. Хадлангийн газрын төлөвлөлт.	186
Хүснэгт-105. Сумын аялал жуулчлалын үндсэн маршрут.	190
Хүснэгт-106. Төлөвлөсөн амралтын газар.	191

График, диаграммын жагсаалт

График-1. Талбайн эзлэх хувь.	18
График-2. Гадаргын гипсометрийн зүсэлт.	20
График-3. Гадаргын хэвгийн эзлэх хувь.	23
График-4. Гадаргын зүг зовхис, эзлэх хувиар.	25
График-5. Сумын агаарын жилийн дундаж температур, сараар.	27
График-6. Сумын агаарын олон жилийн дундаж температур.	28
График-7. Хөрсний гадарга дээрх олон жилийн дундаж температур, °C.	28
График-8. Сумын олон жилийн хур тунадасны үзүүлэлт.	30
График-9. Сумын хөрс үүсгэгч эх чулуулаг эзлэх хувь.	33
График-10. Сумын хөрс үүсгэгч эх чулуулаг эзлэх хувь.	39
График-11. Сумын ургамлын экологийн хэв шинж, эзлэх хувиар.	41
График-12. Сумын бэлчээрийн төрх байдлын эзлэх хувь.	47
График-13. Нөлөөлөлд өртсөн бэлчээрийн талбайн эзлэх хувь.	49
График-14. Ойн төрөл /хувиар/.	51
График-15. Ойн төлөв байдал эзлэх хувь.	53
График-16. Сумын олон жилийн цэвдэгийн тархалтын эзлэх хувь.	66
График-17. Малын динамикаар.	74
График-18. Сумын газрын нэгдмэл сангийн ангилал /Хувь/.	87
График-19. Сумын бэлчээрийн даац хувиар.	94
График-20. Чулуурхаг хөрстэй уулын энгэр болон цав толгодын орой, хажуугийн ботууль-алаг өвст бэлчээрийн төлөв байдлын загвар.	112
График-21. Уулын бэл хөндийн шавранцар хөрстэй жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст бэлчээрийн төлөв байдлын загвар.	113
График-22. Чулуурхаг хөрстэй уулын орой болон энгэр хажуугийн крыловын хялгана-үетэн-алаг өвст бэлчээрийн төлөв байдлын загвар.	114
График-23. Хөнгөн шавранцар хөрстэй уулын бэл хөндийн крыловын хялгана-хазаар өвст бэлчээрийн төлөв байдлын загвар.	115
График-24. Хөрсний гүний ус ойрхон дэрст цайдамт бэлчээрийн төлөв байдлын загвар.	116
График-25. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд	133
График-26. Тариалангийн газрын тохиромжтой байдлын эзлэх хувь.	133
График-27. Ландшафтын үнэлгээний схем.	136
График-28. Аялал жуулчлалын газарт тохиромжтой газрын эзлэх хувь.	136
График-29. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний	138
График-30. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний схем.	140
График-31. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /Өвөл-хавар/.	141
График-32. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /Зун-намар/.	147
График-33. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээний.	153
График-34. Шугаман байгууламжийн тохиромжтой байдлын үнэлгээ.	155
График-35. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний бүсүүд.	165
График-36. Улирлын бэлчээрийн эзлэх хувь.	172
График-37. Бэлчээр усжуулалт хувь.	174

Хавсралтын жагсаалт

Хавсралт-1. Булгийн судалгаа.	199
Хавсралт-2. Нуурын судалгаа.	200
Хавсралт-3. Голын судалгаа.	200
Хавсралт-4. Худаг, уст цэгийн судалгаа.	201
Хавсралт-5. Малчдын байрилын судалгаа.	205

НЭГ. ОРШИЛ

Энэхүү сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулах ажлын гол зорилго нь Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газар болон байгалийн нөөц нөхцлийг зүй зохистой ашиглуулах боломжийг судалсаны үндсэн дээр газрын тохиромжтой байдлын үнэлгээн дээр суурилсан, нутаг дэвсгэрийн цаашдын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад чиглэсэн ажил болно.

Төлөвлөгөөний ажлын зураг төслийг Газрын Харилцаа Геодези Зурагзүйн Газрын Газар зохион байгуулалтын хэлтэс, Хэнтий аймгийн Газрын Харилцаа Барилга Хот Байгуулалтын газар, Монголын газар зохион байгуулагчдын холбоо хамтран боловсрууллаа. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулах арга зүйг Газрын Харилцаа Геодези Зураг Зүйн Газрын даргын тушаалаар батлагдсан аргазүй боловсруулах ажлын хэсгийн гаргасан шийдлийн дагуу тооцож төлөвлөв.

Уг төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, салбарын норм дүрэм, Монгол улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого /2010-2021/, Аймаг, сум, орон нутгийн байгууллага, мэргэжилтнүүд, орон нутгийн иргэдийн саналууд, Хэнтий аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тус тус ашиглав.

Төслийн нэр:	Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө
Төслийн зорилго:	Сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газар болон байгалийн нөөц нөхцлийг зүй зохистой ашиглуулах боломжийг судалсаны үндсэн дээр газрын тохиромжтой байдлын үнэлгээн дээр суурилсан, нутаг дэвсгэрийн цаашдын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад чиглэсэн ажил болно.
Төслийн байршил:	Дэлгэрхаан сумын нийт нутаг дэвсгэр
Төсөлд хамрагдах газрын хэмжээ:	383920.1 га нутаг дэвсгэр
Төсөлд хамрагдах олон нийт:	740 өрх, 2345 хүн ам хамрагдсан

1.1. Төслийн товч танилцуулга.



Төслийн нэр: Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулах

Төслийн зорилго: Сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газарт тохиромжтой байдлын үнэлгээн дээр суурилсан нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулахад оршино.

Төслийн байршил: Хэнтий аймаг, Дэлгэрхаан сум

Төсөлд хамрагдах газрын хэмжээ: Сумын хот тосгон бусад суурины газраас бусад нийт газрыг хамрана.

Төсөлд хамрагдах олон нийт: Сумын 740 өрх, 2345 хүн ам

Төслийн үр дүн: Сумын нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан газар зохион байгуулалтын цогц төлөвлөгөөний бичиг баримт болох нутаг дэвсгэрийн төлөвлөгөөтэй болохоос гадна газар, түүний байгалийн нөөц, ашиглалтын цогц шинэчлэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, газар нутаг, түүний нөөц, баялагийг зүй ёсны зориулалтаар нь ашиглах суурь судалгаа нөхцөл бүрдэж байгаа юм.

1.2. Бүс нутгийн хөгжлийн чиг хандлага, бодлого

Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2010 оны 5-р сарын 22-ний өдрийн 4-р хуралдааны 04 дугаар тогтоолоор батлагдсан “Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого /2010-2021/” -т нийцүүлэв.

Хэнтий аймгийн хөгжлийн хөтөлбөр /2010-2021 он/

Хэнтий аймгийн хөгжлийн алсын хараа: Хэнтий аймгийн хөгжлийн 2021 он хүртлэх алсын хараа нь хүний хөгжилд тулгуурлан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж хүн амын амьдралын түвшинг тууштай дээшлүүлэн, Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, Монгол Улсын өөрөө өөрийгөө тэтгэдэг, оновчтой бүтэвтэй, мэдлэгт суурилсан эдийн засагтай, Зүүн бүсийн цэцэглэн хөгжиж буй аймаг болоход оршино.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он)-ны эцэст эдийн засгийн бүтэц ихээхэн сайжирч, дэвшилтэт техник, технологи, менежмент бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ өсөн мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурь тавигдах ба өмнөх шатанд байгуулагдсан уул уурхайн болон боловсруулах салбарын үйлдвэрүүдийн үйл ажиллагаа жигдрэнэ. Эдийн засаг энэ үе шатанд жилд дунджаар 9.4 хувиар өснө. Аймгийн ДНБ-ний 4.7 хувийг аж үйлдвэр барилгын салбарт, 47.3 хувийг орчин үеийн үйлчилгээний салбар үйлдвэрлэнэ.

Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого:

Хоёрдугаар үе шат (2016-2021 он)

- Стратегийн зорилт 1. Ядуурлыг бууруулахад бүхий л хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тэгш оролцоог ханган ядуурлыг эрс бууруулна.
- Стратегийн зорилт 2. Нэн ядуу иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг боловсронгуй болгоно.

Хүн ам зүйн бодлого:

- Хоёрдугаар үе шат (2016-2021 он)
 - Стратегийн зорилт 1. Хүн амын жилийн дундаж өсөлтийг 2.0 хувьд хүргэнэ.
 - Стратегийн зорилт 2. Хүнийг хөгжүүлэх боломжийг бүрэн дүүрэн ашиглах замаар аймгийн хэмжээнд хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлтийг 0.720-аас бууруулахгүй байна.

Боловсрол, соёлын хөгжлийн бодлого:

- Хоёрдугаар үе шат (2016-2021 он)
 - Стратегийн зорилт 1. Аймгийн боловсролын тогтолцоо, сургалтын хэв шинжийг олон улсын нийтлэг жишигт хүргэнэ.
 - Стратегийн зорилт 2. Соёл урлагийн байгууллагуудын биеэ даан ажиллах оновчтой тогтолцоо бүрдүүлэн, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.

Эрүүл мэндийн хөгжлийн бодлого:

- Хоёрдугаар үе шат (2016-2021 он)
 - Стратегийн зорилт 1. Эрүүл мэндийн салбарын материаллаг баазыг бэхжүүлж, удирдлага, санхүүжилтийн нэгдмэл тогтолцоог хөгжүүлнэ.

Макро эдийн засгийн бодлого:

- Хоёрдугаар үе шат (2016-2021 он)
 - Стратегийн зорилт 1. Энэ үе шатанд тус аймаг жилд 341844.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэж, нэг хүнд ногдох үйлдвэрлэлийн хэмжээ 2021 онд 3829.1 мянган төгрөгт хүрч 2009 онтой харьцуулбал 2.3 дахин нэмэгдэнэ. Аймгийн салбарын бүтцэд томоохон өөрчлөлт гарч ДНБ-ий 25.9 хувийг уул уурхай, боловсруулах үйлдвэр, эрчим хүч, барилгын салбарт, 35.0 хувийг ХАА-н салбарт, 39.18 хувийг үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэнэ.

Боловсруулах аж үйлдвэрийн хөгжлийн бодлого:

- Хоёрдугаар үе шат (2016-2021 он)
 - Стратегийн зорилт 1. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд 2016 онтой харьцуулахад 3.5 хувиар нэмэгдүүлж аймгийн ДНБ-ний 14.8 хувьд хүргэж экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлнэ.

Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого:

- Хоёрдугаар үе шат (2016-2021 он)
 - Стратегийн зорилт 1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн салбарын ДНБ-ийг энэ үе шатанд жилд дунджаар 2.7 хувиар өсгөнө.

Хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого:

- Хоёрдугаар үе шат (2016-2021 он)
 - Стратегийн зорилт 1. Биотехнологийг тууштай нэвтрүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулж, тарималын ургацыг нэмэгдүүлэн ХАА-н салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дундажаар 3.8 хувиар өсгөнө.

Аялал жуулчлалын хөгжлийн бодлого:

- Хоёрдугаар үе шат (2016-2021 он)
 - Стратегийн зорилт 1. Аялал жуулчлалын салбарын жилийн дундаж өсөлтийг 35.4 хувьд хүргэж, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэнэ.

Зам, тээврийн хөгжлийн бодлого:

- Хоёрдугаар үе шат (2016-2021 он)
 - Стратегийн зорилт 1. Автозамын сүлжээг өргөтгөн, агаарын тээврийг эрчимтэй хөгжүүлнэ.

Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого:

- Хоёрдугаар үе шат (2016-2021 он)
 - Стратегийн зорилт 1. Эрчим хүчний менежментийг боловсронгуй болгож, байгаль орчинд халгүй тэргүүний техник технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашгийг дээшлүүлнэ.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн бодлого:

- Нэгдүгээр үе шат (2010-2021 он)

- Стратегийн зорилт 1. Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, сүлжээг шинэчлэх замаар “Мэдээлжсэн нийгэм”-ийг байгуулах суурь үндсийг бүрдүүлнэ.
- Стратегийн зорилт 2. Аймаг сумдын мэдээлэл, харилцаа холбооны дамжуулах сүлжээг шилэн кабель, сансрын холбоо, радио холбоогоор шинэчлэнэ.
- Стратегийн зорилт 3. Мэдээлэл, харилцаа холбооны шинэ үйлчилгээ хэрэглээг төр, аж ахуйн болон үйлчилгээний бүхий л байгууллагуудад өргөн нэвтрүүлнэ.
- Стратегийн зорилт 4. Аймгийн хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны мэргэжилтэн бэлтгэх чадавхийг бүрдүүлэн, хүний нөөцийг хөгжүүлнэ.

Хот байгуулалт, барилгын салбарыг хөгжүүлэх бодлого:

- Хоёрдугаар үе шат (2016-2021 он)
 - Стратегийн зорилт 1. Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан иргэдийн орон сууцны хангамжийн түвшинг дээшлүүлнэ.

Ойн нөөц ашиглалт, хамгааллын талаар:

- Ойг нөхөн сэргээх, төв суурин газрыг цэцэрлэгжүүлэхэд шаардлагатай тарьц, суулгац бэлтгэх мод үржүүлгийн газруудыг Лүн, Эрдэнэ, Мөнгөнморьт, Батсүмбэр, Жаргалант сумдад байгуулж байнгын ажиллагаатай болгох;
- Хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, ойн түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх хохирлыг арилгах арга хэмжээг шинэ шатанд гаргаж, энэ ажилд орон нутгийн иргэдийн оролцоог эрс нэмэгдүүлж, тэдэнд гэрээгээр хариуцуулан хамгаалуулах ойн сангийн хэмжээг нийт ойн сангийн 50 хувьд хүргэх.

Биологийн төрөл зүйлийн хамгааллын талаар:

- Сум бүрийн газар ашиглалтын төлөвлөлтөд биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг хамгаалах асуудлыг тусгаж хэвшүүлэх;
- Ховор ан амьтан үржиж төллөдөг, нүүдлийн болон суурин амьдардаг шувууд өндөглөдөг болон ховор ургамал бүхий газар нутгийг нөөцлөн үлдээх арга хэмжээ авах;
- Байгаль орчны доройтол, биологийн төрөл зүйлийн хомсдлыг хязгаарлан зогсоох, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх ач холбогдол бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах;

ХОЁР. ГЕОЛОГИ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ НӨХЦӨЛ


2.1. Сумын нутаг дэвсгэрийн байршил, тогтоц

2.1.1. Газар зүйн байрлал.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум нь Хэнтийн нурууны урд үзүүр, Хэрлэн голын их тахиралт, Монгол дорнодын талархаг их мужийн хойд хэсэг, улсын нийслэл Улаанбаатар хотоос 232 км, аймгийн төв Өндөрхаан хотоос 124 км-ийн зайтай оршдог.

Дэлгэрхаан сум нь баруун талаараа Төв аймаг, хойд талаараа Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Зүүн хойд талаараа Жаргалтхаан, Зүүн урд талаараа Баянмөнх, Дархан, Говьсүмбэр аймагтай тус тус хиллэх бөгөөд Монгол Хэнтий нурууны урд хойт өргөрөгийн 47 градус, уртрагийн өргөрөгийн 108-109 градуст, далайн түвшнээс дээш дунджаар 1500 метр өндөрт өргөгдсөн, 398.5 мян/га газар нутагтай.

Зураг-1. Газарзүйн байрлал



Дэлгэрхаан сум нь нутгийн хойд хэсгээрээ 1500-1700 метр өргөгдсөн өндөр сүрлэг уулстай урагшлах тусам намсаж голын хөндий тэгш тал, намгархаг болж Хэрлэн голын эрэг хүрдэг. Тус сум 398.5 мян.га нутаг дэвсгэртэй, 704 өрхтэй, үүнээс 470 малчин өрхтэй, амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй салбар юм.


2.1.2. Сумын хилийн цэс

Дэлгэрхаан сум нь 1754 онд Халхын дорно замын баруун гарын дунд баруун этгээдийн хошуунаас тасалж байгуулсан. Манжийн ноёрхлын үед Халхын баруун гарын дунд өмнөд хошуу, 1912-1923 онд Сэцэн хан аймгийн Зоригт бэйсийн хошуу, 1924 оноос, Хан хэнтий уулын аймгийн Дашбалбар уулын хошуу болж 1931 оны 4-р сарын 7-ны өдөр Дэлгэрхаан нэртэйгээр анх сум байгуулагдсан.

Хүснэгт-1. Сумын хилийн цэсийн солбилцол.

Д/д	Хилийн цэсийн тоотын нэр	Өргөрөг	Уртраг
1	Хэрлэн гол 1242.0	47°33'30.4"	108°24'58.5"
2	Зүүн бэрх уул 1584.9	47°33'50.3"	108°26'27.9"
3	1649.9	47°34'26.6"	108°31'04.6"
4	1760.4	47°34'27.9"	108°35'32.1"
5	1847.6	47°33'54.8"	108°40'13.8"
6	1851.3	47°34'28.8"	108°44'46.0"
7	1801.4	47°36'20.9"	108°49'15.0"
8	1879.5	47°38'22.6"	108°54'28.7"
9	Асгат уул 1830.8	47°36'35.8"	108°56'36.9"
10	1756.5	47°35'50.0"	108°58'59.2"
11	1712	47°35'23.6"	109°01'37.5"
12	Баян зүрх 1882.8	47°34'09.0"	109°03'54.9"
13	Их даваа /Бумбат уул/ 1894.9	47°31'53.3"	109°05'34.4"
14	Готолын хөх хана уул 1800.8	47°30'24.4"	109°08'44.8"
15	1519.1	47°28'10.8"	109°10'01.7"
16	1743.6	47°25'45.9"	109°10'40.7"
17	Гурван хушуу уул 1564.9	47°23'56.3"	109°10'24.5"
18	1295.6	47°23'26.9"	109°12'54.2"
19	1278.7	47°19'49.2"	109°15'30.7"
20	1410.6	47°16'14.6"	109°20'18.4"
21	Хөшөө чулуу 1240.1	47°17'06.5"	109°22'13.7"
22	Элстийн гарам	47°16'52.2"	109°24'00.5"
23	Цэнхэрийн голын баруун эргээр, Талын мандал овоо 1164.7	47°10'03.0"	109°30'33.1"
24	Мандалын суурь	47°08'28.0"	109°30'50.7"
25	1225.1	47°06'54.6"	109°29'53.7"
26	Холбоо 1262.4	47°02'34.3"	109°28'26.9"
27	Гүн бүрд	46°58'30.7"	109°28'41.4"
28	Ишгэн толгой 1143.3	46°57'42.4"	109°25'21.1"
29	Жаргалантын үзүүр	46°56'55.2"	109°23'19.4"
30	хэрлэн голын урд эргээр, Дээд хадан хушуу 1148.4	46°57'49.1"	109°15'26.8"
31	Зараа булан	46°58'12.9"	108°57'31.1"
32	Хэрлэн голын хойд эргээр, Хөмүүлтийн гүүрийг дайран өгсөж,	47°00'00.1"	108°50'28.6"
33	Хэрлэн гол 1242.0	47°33'30.4"	108°24'58.5"

Зураг-2. Дэлгэрхаан сумын хилийн цэсийн зураг.



2.1.3. Багийн хилийн цэс

Засаг захиргааны нэгжийн хувьд Хэрлэнбаян-Улаан, Долоод, Аварга, Хэрлэн тооно гэсэн 4 багтай. Багийн хилийг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 2016 онд баталгаажуулсан байна. Хэрлэнбаян-Улаан баг хамгийн их нутагтай буюу 132938.4 га буюу 34.6 хувийг эзэлж байгаа бол төвийн баг болох Аварга баг 91260.2 га буюу 23.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт-2. Багуудын эзлэх газрын хэмжээ, эзлэх хувь.

Д/д	Багийн нэр	Талбайн хэмжээ /га/	Хилийн урт	Эзлэх хувь
1	Хэрлэнбаян-Улаан	132938.4	211.1	34.6
2	Долоод	89527.9	151.8	23.3
3	Аварга	91260.2	156.1	23.8
4	Хэрлэн тооно	70193.5	112.1	18.3
Нийт		383920.1	285.4	100

Хэрлэнбаян-Улаан багийн товч танилцуулга: Монгол усан дөрөв дэх ерөний сайд асан олноо хичээнгүй сайд нэрээр алдаршсан Балингийн Цэрэндорж, ардын гавъяат уран зохиолч Мөрдэндэвийн Ядамсүрэн нарын төрсөн газар 1000 өвөлжөөт, 100 булагт отрын нутаг Хэрлэнбаян-Улаан нь анх БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1962 оны 09-р сарын 12-ний өрдийн 470 дугаар тогтоолоор Хэрлэнбаян-Улааны Отор Тэжээлийн Аж Ахуй нэртэйгээр байгуулагдаж байсан. Хөгжлийн явцад худалдаа үйлчилгээний болон эмнэлэг сургууль, цэцэрлэг, соёлын төв зэрэг байгууллагууд байгуулагдсан зэргийг харгалзан үзэж засаг захиргааны нэгж байгуулах болж, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1974 оны 07-р сарын 27-ны өдрийн 204 дүгээр зарилгаар Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан хороог байгуулж төвийг Дулаан гэж нэрлэсэн байна. 1994 онд орон нутаг засаг захиргааны хуулийн дагуу бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөж Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын 1-р баг болон өөрчлөгдсөн.

Хэрлэнбаян-Улаан тосгон нь байршлын хувьд Хэрлэн голын сав газарт Баян Улаан уулын энгэрт байрладаг бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 220 км, аймгийн төв Өндөрхаан хотоос баруун зүгт 180 км-т оршдог.


Долоод багийн танилцуулга: Долоод баг нь 1958 онд Бэлхийн төвд байгуулагдсан. Тус баг нь Хэрлэнгийн хөдөө арлын тал хээрийн бүсэд оршино.

Аварга багийн танилцуулга: Аварга баг нь Төрийн үйлчилгээний иргэдэд нээлттэй ил тод хөнгөн шуурхай хүргэх эрхэм зорилготой.

Тус баг нь 1992 онд Засаг захиргааны шинэ хуулиар Аварга баг нэртэйгээр байгуулагдаж байсан. Хэнтийн уулархаг мужийн өмнөд дорнод Монголын их тал эзлэх зааг дээр Хангай, тал хээрийн байгалийн зохицол бүрдсэн нутагтай .

Хэрлэн тооно багийн танилцуулга: Хэрлэн тооно баг нь 1958 онд бөөрийн дэнж гэдэг газар байгуулагдсан. Багийн мянгат малчин 15 төрөн гарч 2013 онд баг хамт олноороо оны шилдэг багаар шалгарсан амжилттай ажиллаж байна.


График-1. Талбайн эзлэх хувь.



Хүснэгт-3. Багийн хилийн цэсийн эргэлтийн цэгүүд.

Цэгийн дугаар	Нэр, тоотгой цэг	Х	Ү	Багийн нэр
1		47°03'29.9"N	108°44'18.8"E	Долоод, ХБУлаан
2	Худаг	47°07'28.6"N	108°46'03.8"E	Долоод, ХБУлаан
3	Өндөр толгойн овоо	47°10'23.6"N	108°47'54.7"E	Долоод, ХБУлаан
4	Хар толгойн худаг	47°11'38.0"N	108°48'58.1"E	Долоод, ХБУлаан
5	Гурвалжин	47°13'16.1"N	108°50'06.6"E	Долоод, ХБУлаан
6	Улаан өндөр	47°14'14.6"N	108°52'11.3"E	Долоод, ХБУлаан
7	1662	47°16'19.6"N	108°52'32.1"E	Долоод, ХБУлаан
8	1704.8	47°23'18.0"N	108°48'17.7"E	Долоод, ХБУлаан
9	1737.6	47°24'58.4"N	108°50'30.3"E	Долоод, ХБУлаан
10	Дэлгэрхаан уул	47°27'21.6"N	108°54'32.6"E	Долоод, ХБУлаан, Аварга
11	Бичигт уул	47°28'36.5"N	108°48'58.5"E	ХБУлаан, Аварга
12	Цэнхэр усны гол	47°29'09.6"N	108°48'47.2"E	ХБУлаан, Аварга
13	Баян хан уул	47°32'25.4"N	108°55'44.0"E	Долоод, Хэрлэн тооно
14	Билүүт	47°14'35.1"N	109°17'45.3"E	Долоод, Хэрлэн тооно
15	1429.6	47°11'10.0"N	109°16'01.5"E	Долоод, Хэрлэн тооно
16	1224.3	47°08'33.9"N	109°12'06.0"E	Долоод, Хэрлэн тооно
17	Аваргын глд	47°08'23.4"N	109°11'32.1"E	Долоод, Хэрлэн тооно
18	1809.7	47°22'12.3"N	108°48'49.7"E	Долоод, Хэрлэн тооно
19	Аваргын гол /3 багийн уулзвар/	47°03'45.6"N	109°08'45.8"E	Долоод, Хэрлэн тооно, Аварга

Зураг-3. Багийн хилийн цэсийн зураг.



2.1.4. Газрын гадарга.


Дэлгэрхаан сумын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газар зүйн мужлалаар нутгийн зүүн хэсэг нь Хэнтий нурууны урд үзүүр Хэрлэн голын их тахиралт, Монгол дорнодын талархаг их мужийн хойд хэсэгт хамрагдана. Сумын эдэлбэр нутаг д.т.д 1138-2042 м өндөрт орших ба хамгийн өндөр цэг нь д.т.д 2042 м өргөгдсөн Дэлгэрхаан уул юм.

Газрын гадаргын ерөнхий төрх нь нутгийн хойд хэсгээр уулархаг гадарга зонхилж тэдгээрийн хоорондох өргөн, нарийн ам, хөндийнүүд бүрдүүлнэ. Урагшлах тусам намсаж Сүүжийн тал, Эхэн шандны хонхор, Бугын суга, Хэрлэн голын эрэг хүрнэ.

Хүснэгт-4. Сумын гадаргын өндөржилтийн талбай.


Д/д	Өндөршилт /метр/	Талбай /га/	Эзлэх хувь
1	1133-1200	12843.64	3.3
2	1200-1400	43681.29	11.4
3	1400-1600	66163.46	17.2
4	1600-1800	83024.00	21.6
5	1800-2016	178207.68	46.4
Нийт		38920.08	100

График-2. Гадаргын гипсометрийн зүсэлт.



Сумын гадаргыг баруун хойноос, зүүн урагшаа зүсэлт хийж үзэхэд хойд хэсгээрээ өндөр өргөгдсөн буюу Дэлгэрхаан уул, Баян уул, Баян ханы нуруу хэсгээр хамгийн өндөр дунд хэсгээрээ намсаж Баяны хар тал, Сүүжийн тал урагшлах тутам том хотгор ухаа гүвээт талд шилжинэ. Сумын төв нь Аварга тосон нуур зүүн дэнжид нам дор газар байрласан байна.

Зураг-4. Сумын газрын гадаргын өндөршилт.




2.1.5. Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн мужлал.

Нутаг дэвсгэрийг геологийн бүтэц, уур амьсгал, хотгор гүдгэр, ус зүй, хөрс ба ургамшил, амьтны аймгийн хам бүрдлийн ялгаа, харилцан үйлчлэлийн ижил төстэй нөхцлүүдээр нь мужилж, ашиглалтын үндсэн чиглэлийг тодорхойлох нь газрыг шинжлэх ухааны үндэслэлтэй ашиглах нөхцлийг бүрдүүлдэг. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд монгол улсын нийт нутаг дэвсгэрийг 4 том мужийг хүрээнд 31 тойргоор хувааж нөхцөл нөөцийг үнэлсэн байна. /Д.Даш, Ц.Бадам-УГЗБЕТ-2002/

Энэ үнэлгээгээр Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дэвсгэр нь байгаль-нутаг дэсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлалаар Аварга, Долоод, Хэрлэнбаян-Улаан багийн ихэнх хэсэг нь Хэнтий нурууны тайгын мужийн Хэнтийн зах хаяа уулсын ойт хээрийн тойрог, Хэрлэн тооно багийн хойд хэсэг нь Улз голын савын ойт хээр, хээрийн тойрогт хамрагдаж байгаа бол сумын урд хэсэг Хэрлэн голын орчим Дундад халхын болон дорнод монголын талархаг хээрийн мужийн Хэрлэн голын өмнөд баруун уртын нам уулсын тойрогт тус тус багтаж байна.

Зураг-5. Сумын муж тойрог зураг.




2.1.6. Гадаргын налуу.


Гадаргын хэвгийн хувьд 0-2 градусын хэвгий бүхий газар 157223.4 га буюу 41.0 хувь, 2-4 градусын хэвгий бүхий газар 65416.5 га буюу 17 хувь, 4-6 градусын хэвгий бүхий газар 45023.4 га буюу 11.7 хувь, 6-12 градусын хэвгий бүхий газар 72685.2 га буюу 18.9 хувь, 12-20 градусын хэвгий бүхий газар 33765.9 га буюу 8.8 хувь, 20 дээш градусын хэвгий бүхий газар 9805.7 га буюу 2.6 хувийг тус тус эзэлж байна. Газар тариалангийн аж ахуй эрхлэхэд тохиромжтой 0-4 градусын хэвгий бүхий газар нийт нутаг дэвсгэрийн 57 хувь, 4-12 градусын хэвгий бүхий газар нийт нутаг дэвсгэрийн 30.6 хувийг эзэлж байна.

Хүснэгт-5. Сумын гадаргын өндөржилтийн талбай.

Д/д	Гадаргын хэвгий	Талбай /га/	Эзлэх хувь
1	0-2 градус	157223.4	41.0
2	2-4 градус	65416.5	17.0
3	4-6 градус	45023.4	11.7
4	6-12 градус	72685.2	18.9
5	12-20 градус	33765.9	8.8
6	20-39.5 градус	9805.7	2.6
Нийт		383920.1	100

График-3. Гадаргын хэвгийн эзлэх хувь.

Зураг-6. Гадаргын хэвгийн зураг.




2.1.7. Гадаргын зүг зовхис.


Гадаргын зүг зовхисийн хувьд сумын нутаг дэвсгэрийн 27.3 хувийг хойд, баруун хойд, зүүн хойд буюу 292.5-67.5 градусын зүг зовхис, 44.8 хувийг урд, зүүнурд, баруун урд зүг буюу 112.5-247.5 градусын зүг зовхис, 13.5 хувийг зүүн буюу 67.5-112.5 градусын зүг зовхис, 14.4 хувийг баруун зүг буюу 247.5-292.5 градусын зүг зовхистой гадарга тус тус эзэлж байна.

Хүснэгт-6. Сумын гадаргын зүг зовхисын талбай.

Д/д	Зүг зовхис	Талбай /га/	Эзлэх хувь
1	Хойд(0-22.5)	31100.0	8.4
2	Зүүн хойд(22.5-67.5)	36503.0	9.5
3	Зүүн (67.5-112.5)	51679.4	13.5
4	Зүүн урд (112.5-157.5)	56300.9	14.7
5	Урд (157.5-202.5)	58745.2	15.3
6	Баруун урд(202.5-247.5)	57038.1	14.9
7	Баруун(247.5-292.5)	55342.0	14.4
8	Баруун хойд (292.5-337.5)	35946.2	9.4
Нийт		383920.1	100

График-4. Гадаргын зүг зовхис, эзлэх хувиар.

Зураг-7. Зүг зовхисын зураг.



2.2. Сумын уур амьсгал

Дэлгэрхаан сум нь Монгол орны физик газар зүйн мужлалын хувьд Хангай-Хэнтийн уулархаг их муж Хэнтийн мужийн Хэнтийн захын уулсын тойрог, Монголын дорнод талын их муж Халхын дундад ухаа гүвээт талын тойргийн заагт оршино. Дэлгэрхаан сум нь уур амьсгалын хувьд эрс тэс уур амьсгалтай хуурайдуу сэрүүн зунтай бүсэд нөхцөлд оршино. Хамгийн хүйтэн үе нь 1-р сар бөгөөд дундаж температур нь өвөлдөө -15-аас -40 хэм хүртэл хүйтэрдэг бол хамгийн халуун өдөр нь 7 сард ба зуны дундаж температур +15-аас +37 хэм хүрдэг байна.

Голдуу хаврын улиралд салхины хүч 12м/сек-ээс 14м/сек хүрч зарим үед 16-18м/сек хүрч салхилдаг. Өвлдөө дунджаар 5-аас 10 см зузаан усан бүрхүүл тогтдог. Жилийн анхны бороо 4 сарын эхээр анхны цас 9-р сарын дундуур ордог.

- 1 дүгээр сарын дундаж температур нь -17 °С
- 7 дугаар сарын дундаж температур +24 °С
- Агаарын үнэмлэхүй дулаан 35,5-40 °С дулаан, хамгийн хүйтэн нь 38-40 °С хүрдэг.
- Жилийн дундаж салхины хурд 1,6 м/с


2.2.1. Агаарын температур.

Олон жилийн агаарын дундаж температур -2 хэм, өвлийн хамгийн хүйтэн 1-р сард -35-40 хэм, зуны хамгийн халуун нь +30-35 хэм хүрэх тохиолдол байдаг. Харин өнгөрсөн оны Дэлгэрхаан харуулын станцын мэдээнээс харвал жилийн дундаж температур -0.5⁰С бөгөөд 12 сард хамгийн хүйтэн буюу -22.1⁰С бол 7-р сард хамгийн халуун буюу 20.7⁰С байна.

Хүснэгт-7. Сумын сарын дундаж агаарын температур.

Огноо	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Жилийн дундаж
2015	-18.1	-14.5	-6.8	3.7	10.5	18.5	20.7	18.0	10.3	1.8	-15.9	-22.1	-0.5

График-5. Сумын агаарын жилийн дундаж температур, сараар.




Хүснэгт-8. Сумын агаарын олон жилийн дундаж температур, °C.

Он	2011 он	2012 он	2013 он	2014 он	ОЖД
Жилийн дундаж	1.2	0.0	1.5	3.0	1.4

Сумын агаарын олон жилийн дундаж температур 1.4 °C байгаа бөгөөд тус сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна.

График-6. Сумын агаарын олон жилийн дундаж температур.




Сумын хөрсний гадарга дээрх олон жилийн дундаж температур нь өвлийн 1, 2 дугаар сард -19.8°C, хамгийн дулаан нь 7 дугаар сард 25.4 °C байгаа нь температурын зөрүү төдийлэн их бишийг харуулж байна. Энэ нь хадлан, бэлчээр болон таримал ургамлын ургалтанд сайнаар нөлөөлж байна.


Хүснэгт-9. Хөрсний гадарга дээрх олон жилийн дундаж температур, °C.

Станц	Сарууд												ОЖД
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
Дэлгэрхаан	-19.8	-15.4	-2.4	8.1	17.1	23.8	25.4	24.0	15.2	4.6	-9.7	-19.2	4.3

График-7. Хөрсний гадарга дээрх олон жилийн дундаж температур, °C.



Зураг-8. Агаарын температур.




2.2.2. Хур тунадас.

Агаар мандлын орчил урсгал, орон нутгийн хотгор гүдгэрийн байдал, дэвсгэр гадаргын ууршил зэргээр хур тундасны горим тодорхойлогдоно. Хур тунадасны хэмжээ. Олон жилийн дундаж байдлаар тус сумын хойд уулархаг хэсгээр 300-325 мм, өмнөд хэсгээр 225-250 мм-ээс бага хур тунадас ордог байна. Дэлгэрхаан харуулын станцын мэдээнээс харвал хар тундасны нийлбэр 241 мм бол үүнийн 227 мм нь дулааны улиралд унасан бол 14 мм нь хүйтний улиралд унасан байна. Хамгийн их хур тундас унадаг сар нь 8-р сард 109 мм байна.


Хүснэгт-10. Сумын сарын хур тундас.

Станц, харуулын нэр	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Нийлбэр	Дулаан үе	Хүйтэн үе
Дэлгэрхаан	1.1	0.0	1.0	9.0	3.3	5.1	81.2	109.0	20.2	3.9	6.1	1.2	241	227	14

График-8. Сумын олон жилийн хур тунадасны үзүүлэлт.

Өвлийн улиралд цасан бүрхүүлийн дундаж зузаан 2,5 см-ээс хэтэрдэггүй ба 11 дүгээр сарын сүүлчээс 3 дугаар сар хүртэл тогтвортой цасан бүрхүүлтэй байдаг.

Зураг-9. Хур тунадас.



2.3. Хөрс, хөрсөн бүрхэвч

2.3.1. Хөрс үүсгэгч чулуулаг.

Дэлгэрхаан сумын нутгийн хөрс үүсгэгч чулуулаг нь делювийн хурдас, элювийн хурдас, элювийн хурдас, элюви-делювийн хурдсаас бүрдэнэ. Нилээд их хэмжээгээр делювийн хурдас 44.9 хувьд, элювийн хурдас 42.4 хувьд тус тус тархсан байна.

Хүснэгт-11. Сумын хөрс үүсгэгч эх чулуулаг, талбай, хувь.

Д/д	Хөрс үүсгэгч чулуулаг	Талбай, га	Эзлэх хувь
1	Аллювийн хурдас	47058.39	12.3
2	Делювийн хурдас	162892.95	42.4
3	Элюви-делювийн хурдас	1682.81	0.4
4	Элювийн хурдас	172285.80	44.9
Нийт		383919.96	100.0

Элювийн хурдас: нутгийн 44.9 хувьд тархсан. Энэ хурдас нь голдуу уулын орой хяр нурууг дагаж том том хад чулуу, байц цохионуудын байдалтай тохиолдоно. Элювийн хурдасны онцлог нь нэг тогтсон байрандаа тогтмол байж байдаг онцлогтой бөгөөд түүний бүрэлдэхүүнд хад чулуунаас гадна элс сайр, шавранцар элсэнцэр хүртэл ихээхэн хэмжээгээр байна.


Делювийн хурдас: нутгийн 42.4 хувьд тархсан. Энэ хурдас нь уул толгодын хоорондох өргөн, нарийн хөндий, уулын хормой бэл, хужирлаг мараат нуга зэрэг газраар тархана. Энэ хурдас нь байгалийн янз бүрийн хүчин зүйлийн /салхи, ус, газар хөдлөлт/ нөлөөгөөр нэг байрнаас нөгөө байранд шилжин гулсах замаар анхныхаа байршлыг өөрчилдөг онцлогтой. Хурдсын бүрэлдэхүүнд элс хайрга, шавар жижиг чулуу, хурц ирмэг бүхий чулуулгууд хамрагдана.

Делювийн хурдас гол төлөв карбонатлаг шинж чанартай байхаас гадна түүний орчин нь гол төлөв шүлтлэгдүү байна. Энэ хурдсан дээр ихэнх тохиолдолд цайвар хүрэн, цөлөрхөг хээрийн бор, цайвар бор, цөлийн бор саарал нугын хөрсний янз дүрсүүд тархжээ. Механик бүрэлдэхүүний хувьд тоос ба элс давамгайлсан шавранцар эсвэл элсэрхэг ба элсэнцэр байдаг. Ийм хурдас нь нилээд зузаантайгаар хотгор газраар тархах ба голдуу карбонатлаг байна. Карбонат дахь нүүрсхүчлийн агууламж үлэмж их .


Аллювийн хурдас: нь нутгийн 12.3 хувьд тархсан. Аллювийн хурдас нь голын хөндийн сав газар ялангуяа дэнж татам нуга, нуурын хөвөөгөөр элбэг тохиолдоно. Мөн голын дэнж уулын бэл хормойн хэсгээр аллювийн хурдас нь 0.5-1.5 м хүртэл зузаан үе давхаргыг үүсгэж тогтсон байна. Аллювийн хурдасны зузаан нь томоохон гол, нуурын хөндийд 10-15м хүртэл байх бөгөөд ихэвчлэн элс, хайрга, элсэнцэр, шавранцар механикийн бүрэлдэхүүнтэй байна. Зарим их намагтай газраа шаварлаг хурдас ихээхэн

хэмжээгээр тархах боловч тэнд линз хэлбэрийн элс, хайрган давхаргыг үүсгэдэг байна. Эндэхийн томоохон голын хөндийнүүдэд ихэвчлэн дан хайргархаг-элсэнцэр, элсэнцэр хурдас зонхилж давсархаг карбонатлаг шинж чанарын хувьд янз бүр байна. Аллювийн хурдас нь өөрийнхөө бүрэлдэхүүнд том жижиг янз бүрийн хэмжээтэй бөөрөнхий хэлбэрийн хайрга чулуулгуудыг агуулан үелэн тогтсон байдлаараа онцлогтой байна.

График-9. Сумын хөрс үүсгэгч эх чулуулаг эзлэх хувь.



Зураг-10. Хөрс үүсгэгч чулуулгийн зураг.



2.3.2. Хөрсний хэв шинж.

Сумын хөрсөн нийт 17 хэв шинжийн хөрс тархсан бөгөөд хамгийн их тархсан хөрс нь 25.3 хувийг эзлэх уулын хүрэн хөрс бол дараа нь 22.9 хувийг жинхэнэ хүрэн хөрс, 14.8 хар хүрэн, 14.6 хувийг уулын хар хүрэн хөрс тус тус хамгийн түгээмэл тархсан бол бусад нь бага хэмжээгээр тархсан байна.

Хүснэгт-12. Сумын хөрсний хэв шинж /талбай-га, %/.

Д/д	Хөрсний хэв шинж	Талбай, га	Эзлэх хувь
1	Аллювийн нуга-намгийн хөрс	9294.1	2.4
2	Аллювийн нугын сулавтар хөгжилтэй хөрс	16347.4	4.3
3	Аллювийн нугын хөрс	19288.7	5.0
4	Аллювийн ширэгт хөрс	2128.1	0.6
5	Гүйцэт бус хөгжилтэй хүрэн хөрс	7547.3	2.0
6	Далд глейрхэг хар шороон хөрс	4386.1	1.1
7	Жинхэнэ хүрэн хөрс	88028.8	22.9
8	Нугын хужир /Чийгт хэлбэрийн хужир/ хөрс	1737.6	0.5
9	Нугын хүрэн хөрс	11101.8	2.9
10	Өндөр уулын нугын ердийн хөрс	6179.2	1.6
11	Уулын ердийн хар шороон хөрс /карбонатлаг биш/	1348.6	0.4
12	Уулын ойн ширэгт бараан хөрс	3005.7	0.8
13	Уулын ойн ширэгт ердийн /жинхэнэ/ бараан хөрс	1399.3	0.4
14	Уулын хар хүрэн хөрс	55937.5	14.6
15	Уулын хүрэн хөрс	97201.3	25.3
16	Уулын ширэгт тайгын чандруулаг хөрс	2228.3	0.6
17	Хар хүрэн хөрс	56759.9	14.8
Нийт		383920.0	100

Уулын хүрэн хөрс: Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 97201.3 га буюу нутаг дэвсгэрийн 25.3 хувийг эзлэн тархсан байна. Уулын хүрэн хөрс нь нам ба бэсрэг уулсын элювийн хурдас дээр тогтоно. Уулын хүрэн хөрсний үе давхаргууд нь харьцангуй нимгэн чулуурхаг бөгөөд гүн рүүгээ чулууны хэмжээ улам ихэснэ. Бага зэрэг чулуурхаг хувилбарт ялмагт давхаргад нь 10 хүртэл хувийн чулуу агуулагдана.

Ялмагт давхарга нь голдуу бөөмөрхөг бүтэцтэй, 15-16 см-ийн зузаантай бөгөөд хөрс үүсэгэгч эх чулуулгийн давхарга нь 21-42 см-т оршино.

Ялмагийн агууламж 4.7% (хавсралт 4) бөгөөд шингээгдсэн суурийн нийлбэрт кальцийн катион давамгайлна. Хөдөлгөөнт фосфорын хангамж ядуу. Хөрсний орчин рН саармаг ба сулавтар шүлтлэг.

Жинхэнэ хүрэн хөрс: Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 88028.8 га буюу нутаг дэвсгэрийн 22.9 хувийг эзлэн тархсан байна. Тус хөрс нь ихэвчлэн уулын хоорондох нарийхан ам хөндий түүний ёроолын тэгшивтэр хэсэг, налуувтар хажуунууд, голын дэнж, нуур цөөрмийн ойролцоох хотгор, тэгшивтэр гадаргад голлон тархана. Хотгор хөндийн хөрс нь далайн түвшнээс дээш 1500-2300 м өндөрт өргөгдсөн байгалийн үржил шим гадаргын байдлаараа арай илүү тохиромжтой байдгаас ялангуяа хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг /хадлан бэлчээр, тариалан/ энэ хөрсөн дээр явуулдаг юм. А үе

давхарга нь бараандуу хүрэн өнгөтэй, бага зэрэг чийгтэй, нягт, үйрмэг чулуу ихтэй, бөөмөрхөг сулавтар үрлэн бүтэцтэй, ургамлын үндсээр бага, хөнгөн шавранцар, шилжилт аажим

Энэ хөрсний шингээх сууриудын катионы нийлбэр ялзмагт үе давхаргад 100 гр хөрсөнд 26,26-29,58 мг/экв байх боловч үе давхарга доошлох тутам аажмаар ихсэж байгаад хөрс үүсгэгч эх чулуулагтаа 100 гр хөрсөнд 40,40 мг/экв болтол ихэссэн. Харин хөрсний урвалын орчны ялзмагт үе давхаргатаа сулхан хүчиллэг байгаад доошлоход саармаг орчинд дөхөж байв.

Хар хүрэн хөрс: Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 56759.9 га буюу нутаг дэвсгэрийн 14.8 хувийг эзлэн тархсан байна. Хар хүрэн хөрсний өнгөн гадаргад болон профилд чулуурхаг -10% хүрч байгаа нь бага зэргийн чулуурхаг хөрсөнд хамрагдана. Хөрсний ялзмагт үе давхаргын дундаж зузаан 28 см хүрэх ба ерөнхийдөө 26-29 см-т хэлбэлзэнэ.

Элсэрхэг хөрсөнд карбонатын агууламжаас хамаарч нилээд шүлтлэг шинжтэй байна, давсны хүчилд 46-52 м-т бургилт үзүүлнэ. Механик бүрэлдэхүүнээр дунд шавранцар болон элсэнцэр төрлөөр илэрнэ. Шавранцар хөрсөнд шаварлагын зүйл 32,9%, элсэнцэр хөрсөнд 15,1-17,7% хүрнэ. Дунд шавранцар төрөлд том ширхэгтэй тоос 32,0% хүрч, элсэн фракци 17,9% хүрнэ. Элсэнцэр хөрсөнд элс ихтэй 60,9-71,0% хүрч, тоосны агууламж буурч 9,5-9,8% байна.

Хар хүрэн хөрсний дээд давхарга ялзмаг ихтэй, дунд шавранцар төрөлд 4,9%, элсэнцэрт 2,4-2,6%, ерөнхий азотын хэмжээ дунд шавранцар төрөлд мөн өндөр 0,22% байна. Хөрсний ялзмагийн агууламж болон механик бүрэлдэхүүнээс хамаарч шингээгдсэн сууриудын нийлбэр дээд давхаргад 100 г хөрсөнд 12,3-33,3мг/экв хүрч кальци давамгайлна.


Хөрсний урвалын орчин ургамлын үндэстэй хэсэгтээ саармагт ойр шинжтэй рН 6,6-7,0 үе давхаргын доод хэсэгт шүлтлэг рН 7,5-7,7 орчинтой байна. Хөрсний шимт бодисын хангамж харилцан адилгүй, элсэнцэр төрөлд фосфорын хангамж өндөртэй /100 г хөрсөнд 2,28-3,16мг/, солилцоот кали дунд шавранцар болон элсэнцэр хөрсөнд их биш байна.

Уулын хар хүрэн хөрс: Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 55937.5 га буюу нутаг дэвсгэрийн 14.6 хувийг эзлэн тархсан байна. Энэ бага хэв шинжийн хөрс нь уулын тагт, баруун ба баруун хойд ар талын хажууг дагаж хар шороон хөрснөөс арай доогуур бүсэд уулынхаа бусад хөрстэйгөө бүрдлийн байдалтайгаар тархана. Хар хүрэн хөрсний ялзмагт үеийн зузаан дунджаар 15-25 см орчимд хэлбэлзэх бөгөөд бараандуу

харавтар хүрэн өнгөтэй, хуурайвтар, чулуурхаг, тоосорхог, бөөмөрхөг бүтэцтэй ихэвчлэн дунд хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна.

Ялзмагт үеийн дараагаар цайвардуу бор буюу бор саарал өнгөтэй нягтарсан чийлэг нэлээд чулуурхаг хаяа карбонаттай, карбонатгүй гол төлөв элсэнцэр, шавранцар механик бүрэлдэхүүнтэй эллювийн В давхарга эхэлнэ. Энэ давхарга төдий л зузаан биш 10-20 см үргэлжлээд маш их хэмхдэс бутармал чулуу бүхий С давхарга эхэлнэ.

Зураг-11. Хөрсний тархалтын зураг.




2.3.3. Сумын хөрсний механик бүрэлдэхүүн.

Сумын нутаг дэвсгэрийн 59.6 хувийг хөнгөн шавранцар, 35.4 хувийг элсэн механикийн бүрэлдэхүүнтэй хөрс хамгийн их тархсан бол бага буюу 2 хувийг дунд шавранцар, 1.6 хувийг хүнд шавранцар, 1 хувьд шаварлаг механик бүрэлдэхүүнтэй хөрс тархсан байна.


Хүснэгт-13. Сумын хөрсний механик бүрэлдэхүүн талбай, га.

Д/д	Механик бүрэлдэхүүн	Талбай, га	Эзлэх хувь
1	Шаварлаг	5234.0	1
2	Хүнд шавранцар	6085.0	1.6
3	Хөнгөн шавранцар	228864.9	59.6
4	Дунд шавранцар	7800.5	2.0
5	Элс	135935.5	35.4
Нийт		383919.96	100

График-10. Сумын хөрс үүсгэгч эх чулуулаг эзлэх хувь.



Зураг-12. Хөрсний механик бүрэлдэхүүн.



2.4. Ургамалжилт


2.4.1. Сумын ургамлын экологийн хэв шинж.

Дэлгэрхаан сумын гадарга нь өөр хоорондоо ялгаа бүхий ландшафттай бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 38.4 хувийг дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр ургамал, 35.3 хувийг тал хээрийн бэлчээрийн ургамал, 10.2 хувийг бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээрийн ургамал, 5.8 хувийг нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндийн бэлчээрийн ургамал тус тус тархсан байна.


Хүснэгт-14. Сумын ургамалын экологийн хэв шинж.

Д/д	Ургамлын хэв шинж	Талбай, га	Эзлэх хувь
1	Хадлан	11749.6	3.1
2	Нуур	87.8	0.0
3	Ой	26296.1	6.8
4	Тариалан	1774.8	0.5
5	Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр	147252.4	38.4
6	Нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндий	22184.8	5.8
7	Тал хээрийн бэлчээр	135447.8	35.3
8	Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр	39126.6	10.2
Нийт		383920.0	100

График-11. Сумын ургамлын экологийн хэв шинж, эзлэх хувиар.



Зураг-13. Ургамлын экологийн хэв шинжийн зураг.



2.4.2. Сумын бэлчээрийн ургамалжилт, төрөл.

Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд 40 гаруй хэв шинжийн ургамалжилт илэрсэн байна. Үүнээс хамгийн түгээмэл тархсан нь 27.3 хувийг уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээрийн ургамал, 26.3 хувийг тэгшивтэр хөндийн элсэнцэр хүрэн хөрстэй хээрийн бэлчээрийн ургамал, 13.1. тэгшивтэр болон нугачаат хөндийн шавранцар хөрстэй хээрийн бэлчээрийн ургамал тус тус тархсан байна.

Хүснэгт-15. Сумын бэлчээрийн ургамалын анги.

Ангилалын шифр	Бэлчээр хадлангийн анги	Талбайн хэмжээ	Эзлэх хувь
У-II	Уулын хар хүрэн ба нугын улирлын цэвдэгт хар шороон хөрстэй нугархаг хээр	9630.1	2.8
У-III	Уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн ДЗсийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр	3078.7	0.9
У-IV	Уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр	93791.1	27.3
У-V	Уулын сул хөгжилтэй хүрэн, цайвар хүрэн хөрстэй сийрэг ургамалтай чулуурхаг хээр	40752.5	11.8
УХ-II	Уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нуга	22184.8	6.4
Х-I	Тэгшивтэр болон нугачаат хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээр	44925.5	13.1
Х-II	Тэгшивтэр хөндийн элсэнцэр хүрэн хөрстэй хээрийн бэлчээр	90522.3	26.3
Н-I	Голын хөндий нуурын захын аллювийн нугат намгийн хөрстэй нуга намгийн бэлчээр	5079.3	1.5
Н-II	Аллювийн нугын болон хээржсэн нугын үелсэн сулавтар хөгжилтэй хөрстэй татамын нуга	21991.6	6.4
Н-III	Голын хөндий, нам хотосын аллювийн нугын ба нугын хээржсэн хөрстэй давсархаг нуга	11488.0	3.3
Н-IV	Хужир мараатай нугын хээржсэн хөрстэй нам хотосын нуга	567.6	0.2
Нийт		344011.6	100.0


Хүснэгт-16. Сумын бэлчээрийн ургамалын төрөл зүйл.

Д/д	Зураг дээрхи индекс	Ангилалын шифр	Бэлчээр хадлангийн анги, бүлэг төрөл, төрлүүдийн нэр	Талбайн хэмжээ
		У	Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр	
		У-II	<i>Анги: Уулын хар хүрэн ба нугын улирлын цэвдэгт хар шороон хөрстэй нугархаг хээр</i>	
		У-II-3	Бүлэг төрөл: Алаг өвст	
1	24	У-II-3-2	Алаг өвс - үетэн - улалжит	2754.1
2	26	У-II-3-4	Зүр өвс - хялганат	6876.0
		У-III	<i>Анги: Уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр</i>	
		У-III-1	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт	
3	29	У-III-1-2	Ботууль - алаг өвст	3078.7

		У-IV	Анги: Уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр	
		У-IV-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт	
4	32	У-IV-2-1	Ботууль - алаг өвст	41107.4
5	36	У-IV-2-5	Хялганат, Хялгана - алаг өвст	27816.3
6	37	У-IV-2-6	Хялгана - зүр өвст	15095.0
7	39	У-IV-2-8	Хялгана -үетэнт	1501.3
8	40	У-IV-2-9	Хялгана - хазаар өвст	1524.6
9	42	У-IV-2-11	Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст	4890.9
10	44	У-IV-2-13	Үетэн - алаг өвст	85.3
11	45	У-IV-2-14	Хазаар өвс - хялганат	655.0
12	46	У-IV-2-15	Хазаар өвс - үетэнт	1115.3
		У-V	Анги: Уулын сул хөгжилтэй хүрэн, цайвар хүрэн хөрстэй сийрэг ургамалтай чулуурхаг хээр	
		У-V-1	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт	
13	49	У-V-1-2	Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвс - агьт	22359.3
14	50	У-V-1-3	Хялгана - алаг өвст	18051.0
15	54	У-V-1-7	Үетэн - хялганат	33.6
		У-V-2	Бүлэг төрөл: Алаг өвст	
16	56	У-V-2-1	Алаг өвс - агь - үетэн	308.6
		УХ	Нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндий	
		УХ-II	Анги: Уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нуга	
		УХ-II-1	Бүлэг төрөл: Үндэслэг ишт үетэнт	
17	82	УХ-II-1-1	Үетэн - алаг өвст	2649.7
18	83	УХ-II-1-2	Хиагт, Хиаг - алаг өвст	7004.4
		УХ-II-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт	
19	88	УХ-II-2-4	Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст хээржсэн нуга	4604.8
		УХ-II-3	Бүлэг төрөл: Алаг өвст	
20	92	УХ-II-3-2	Зүр өвст	320.8
		УХ-II-4	Бүлэг төрөл: Улалжит	
21	96	УХ-II-4-1	Улалж - үетэнт	7605.1
		Х	Тал хээрийн бэлчээр	
		Х-I	Анги: Тэгшивтэр болон нугачаат хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээр	
		Х-I-1	Бүлэг төрөл: Үндэслэг ишт үетэнт	
22	98	Х-I-1-1	Хиагт, Хиаг-алаг өвст	2861.0
		Х-I-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт	
23	102	Х-I-2-1	Ботууль-жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст	1405.3
24	104	Х-I-2-3	Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт	12527.8
25	105	Х-I-2-4	Хялгана-хиагт	5541.3
26	106	Х-I-2-5	Хялгана-хазаарт	9899.8
27	110	Х-I-2-9	Хялганат, хялгана-алаг өвст	4921.2
28	114	Х-I-2-13	Жижиг дэгнүүлт үетэн-хялганат	967.1
		Х-I-4	Бүлэг төрөл: Улалжит	
29	120	Х-I-4-1	Жижиг улалж- үетэнт	6802.0

		Х-II	<i>Анги: Тэгшивтэр хөндийн элсэнцэр хүрэн хөрстэй хээрийн бэлчээр</i>	
		Х-II-1	Бүлэг төрөл: Үндэслэг ишт үетэнт	
30	121	Х-II-1-1	Хиагт	149.8
		Х-II-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт	
31	124	Х-II-2-3	Жижиг дэгнүүлт үетэн - хялганат	783.1
32	130	Х-II-2-9	Хазаар өвс- хиагт	5304.7
33	131	Х-II-2-10	Хазаар өвс- жижиг дэгнүүлт үетэнт	48040.4
34	132	Х-II-2-11	Хазаар өвс- хялганат	29766.6
		Х-II-3	Бүлэг төрөл: Алаг өвст	
35	134	Х-II-3-2	Агь- үетэнт	6477.6
		Н	Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр	
		Н-I	<i>Анги: Голын хөндий нуурын захын аллювийн нугат намгийн хөрстэй нуга намгийн бэлчээр</i>	
		Н-I-2	Бүлэг төрөл: Улалжит	
36	194	Н-I-2-1	Улалжит	4137.8
37	197	Н-I-2-4	Улалж-алаг өвст	941.6
		Н-II	<i>Анги: Аллювийн нугын болон хээржсэн нугын үелсэн сулавтар хөгжилтэй хөрстэй татамын нуга</i>	
		Н-II-1	Бүлэг төрөл: Үндэслэг ишт үетэнт	
38	200	Н-II-1-3	Хиагт, Хиаг-алаг өвст	668.9
		Н-II-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт	
39	202	Н-II-2-2	Үетэн-цахилдаг - алаг өвст	5001.8
40	203	Н-II-2-3	Үетэн-улалж-алаг өвст	3437.5
41	204	Н-II-2-4	Улаан толгой-алаг өвст	9152.0
		Н-II-4	Бүлэг төрөл: Улалжит	
42	208	Н-II-4-1	Улалж-үетэн-алаг өвст	1819.2
		Н-II-5	Бүлэг төрөл: Мод сөөгт төгөл	
43	213	Н-II-5-5	Харганын ширэнгэ	1912.2
		Н-III	<i>Анги: Голын хөндий, нам хотосын аллювийн нугын ба нугын хээржсэн хөрстэй давсархаг нуга</i>	
		Н-III-3	Бүлэг төрөл: Нягт дэгнүүлт үетэнт	
44	221	Н-III-3-2	Дэрс-хиаг-алаг өвст	8648.0
		Н-III-4	Бүлэг төрөл: Алаг өвст	
45	226	Н-III-4-1	Алаг өвс-үетэнт (лууль шарилжтай)	7.6
46	227	Н-III-4-2	Цахилдаг- үетэнт (тор өвстэй)	2832.4
		Н-IV	<i>Анги: Хужир мараатай нугын хээржсэн хөрстэй нам хотосын нуга</i>	
		Н-IV-1	Бүлэг төрөл: Шарилжит	
47	230	Н-IV-1-1	Шарилж-үетэнт	567.6

Зураг-14. Ургамалжилтын зураг.




2.4.3. Сумын бэлчээрийн ургамалжилтийн төрх байдал, төлөв.

Бэлчээрийн төрх байдал: Сумын нийт нутаг дэвсгэрийн бэлчээрийн төрх байдлын 42.1 хувийг сөөгтэй бэлчээр, 36.7 хувийг чулуутай бэлчээр, 10.7 хувийг довонтой бэлчээр 8.5 хувийг цэвэр бэлчээр тус тус эзэлж байна. Ашиглагдахгүй бэлчээрт 15478 га буюу нийт талбайн 1,9 %-ийг нуур, заган ой, элс, хад асга эзлэж байна.


Хүснэгт-17. Сумын бэлчээрийн төрх байдал (талбай, %).

Д/д	Бэлчээрийн төрх байдал	Талбай, га	Эзлэх хувь
1	Хадлан	11749.65	3.1
2	Тариалан	1774.84	0.5
3	Нуур	87.79	0.0
4	Ой	26296.06	6.8
5	Цэвэр бэлчээр	148136.78	38.6
6	Чулуутай бэлчээр	80469.37	21.0
7	Сөөгтэй бэлчээр	71365.47	18.6
8	Довонтой бэлчээр	44040.03	11.5
Нийт		383919.98	100.0

График-12. Сумын бэлчээрийн төрх байдлын эзлэх хувь.



Зураг-15. Бэлчээрийн төрх байдлын зураг.



2.4.4. Бэлчээрийн төлөв байдал


Бэлчээрийн төлөв байдал: Сумын аж ахуйн үндсэн чиглэл нь уламжлалт мал аж ахуй эрхэлдэг бөгөөд бэлчээрийн даац баг багаар харилцан адилгүй өөр өөр бөгөөд хамгийн их бэлчээрийн даац хэтэрсэн баг нь Аварга баг 4.6 дахин хэтэрсэн бөгөөд бусад баг хэдийгээр Аварга багаас арай бага даац хэтэрсэн судалгаа гарсан боловч энэ даацанд отрын орж ирж өвөлжиж хаварждаг малын тоо оролцоогүй тул бусад багийн даац үүнээс дээрдэх зүйл байхгүйг тул сумын нийт бэлчээр талхлагдаж байгааг харуулж байна.

Талхлагдалд орсон бэлчээрийг их, дунд, бага гэсэн үзүүлэлтээр ангилаж гаргахад их талхлагдалд орсон бэлчээр нь Их ишгэн буюу Хэрлэн голоо дагаад, Сүүжийн тал, сумын төв, Аварга тосон нуур, Замагт нуур, Аварга голыг дагасан бэлчээрүүд байна. Дунд зэрэг талхлагдалд орсон бэлчээр нь Шар нохойтын тал, Зүүн баян булагийн ам, Мухар хошуу уулын орчмын бэлчээр, Өндөр улаан уулын ам хөндий, Долоолд багийн төвийн ор орчмын бэлчээрүүд байна. Харин бага зэрэг талхлагдалд орсон буюу цаашид их болон дунд хэмжээгээр талхлагдалд өртөх магадлалтай бэлчээрт Уст Хар өндөр уулын орчмын бэлчээр, Хар талын бэлчээр, Майхан толгой орчим, Уушиг толгой орчим, Нарийн ам Долоод уул орчмын бэлчээрүүд байна. Мөн Хэрлэн тоонот багийн Тоонот уулын өврөөр бага хэмжээний элсний нүүлттэй өртсөн, Эхэн шандны хөндийн баруун Хэрлэн голын хөвөөгөөр усны элэгдэлд орсон байна.


Хүснэгт-18. Нөлөөлд өртсөн бэлчээрийн талбай.

Д/д	Талхлагдлын зэрэг	Талбай, га	Эзлэх хувь
1	Дунд зэрэг талхлагдсан	39237.1	30.2
2	Их талхлагдсан	63907.9	49.2
3	Бага зэрэг талхлагдсан	26819.8	20.6
Нийт		129964.8	100.0

График-13. Нөлөөлд өртсөн бэлчээрийн талбайн эзлэх хувь.



Зураг-16. Бэлчээрийн төлөв байдлын зураг.



2.5. Ойн нөөц, төлөв байдал


2.5.1. Сумын ойн нөөц.

Сумын хойд хэсэг уулархаг нутгаар хэсэгхэн ой ургах бөгөөд энэ хэсэгхэн ой нь нийт сумын дөнгөж 3.8 хувийг эзлэх бөгөөд Баянханы нуруу, Дэлгэрхаан уул, Түмэн уул орчид л ургац байна. Ойн газрын 76.4 хувийг торлог буюу сөөгөрхөг мод ургасан бол, 17.6 хувийг шинэс мод ургасан байна.


Хүснэгт-19. Сумын нутаг дэвсгэрт тархсан ойн төрөл.

Д/д	Ойн төрөл	Талбай, га	Эзлэх хувь
1	Бургас	245.52	1.7
2	Хус	307.09	2.1
3	Шинэс	2604.33	17.6
4	Торлог	11339.14	76.4
5	Цагаан энгэр	341.11	2.3
Нийт		14837.18	100.0

График-14. Ойн төрөл /хувиар/.



Зураг-17. Ойн төрлийн зураг.




2.5.2. Ойн төлөв байдал.


Ойгоор бүрхэгдсэн талбай нь ойн нийт талбайн 90.6 хувийг эзэлж байгаа бол ойгоор бүрхэгдээгүй нь 9.4 хувийг эзэлж байна. Ойгоор бүрхэгдсэн талбайн хамгийн их хувийг 76.4 хувийг торлог эзэлж байгаа бол байгалийн ойн нь 14.2 хувийг эзэлж байгалийн ойн хамгийн эх хувийг болц гүйцсэн шинэс 9.2 хувийг эзэлж байна. Ойгоор бүрхэгдээгүй талбайн 3.8 хувийг тармаг ой бүрхэгдсэн талбай эзэлж байна.

Хүснэгт-20. Ойн төлөв байдал /талбай, %/.

Д/д	Ойн төлөв байдал		Талбайн хэмжээ /га/	Нийт ойн талбайд эзлэх хувь
Ойгоор бүрхэгдсэн				
1	Байгалийн ой	Болц гүйцсэн шинэс	1372.12	14.2
		Дунд насны бургас	112.79	
		Дунд насны хус	27.15	
		Дунд насны шинэс	371.33	
		Залуу бургас	51.58	
		Залуу хус	169.36	
	Залуу шинэс	1.6		
2	Торлог		11339.12	76.4
Ойгоор бүрхэгдээгүй				
3	Тармаг ой	Тармаг бургас	81.15	3.8
		Тармаг хус	24.68	
		Тармаг шинэс	453.51	
5	Шатсан ой	Шатсан хус	85.90	3.3
		Шатсан шинэс	405.76	
4	Цагаан энгэр		341.13	2.3
Нийт			14837.18	100

График-15. Ойн төлөв байдал эзлэх хувь.

Зураг-18. Ойн төлөв байдлын зураг.



2.6. Гадаргын болон гүний усны нөөц

2.6.1. Гадаргын усны нөөц.

Дэлгэрхаан сум нь нийт 140 гадаргын устай бөгөөд үүнээс 38 булаг, шанд, 80 худаг, 12 нуур, 9 голтой мөн 1 рашаан, рашаан төст гадаргын уст цэг байна /гадаргын усан хангамжийн дэлгэрэнгүй мэдээллийг *хавсралтаар*/. Гадаргын усан хангамж харьцангуй сайн бөгөөд сумын урд хэсгээр Хэрлэн гол болон түүний ай савын нөлөө байдаг.

Хүснэгт-21. Сумын уст цэгийн тоо.

Багийн нэр	Булаг	Худаг	Гол	Нуур	Рашаан, Рашаан төст	Дүн
Хэрлэнбаян-Улаан	15	18	4			37
Долоод	7	24	2	8		41
Аварга	10	22	4	4	1	41
Хэрлэн тооно	6	16	2			18
Нийт	38	80	9	12	1	140

Хэрлэн гол нь Номхон далайн ай савын гол мөрнүүд дотор уртын хэмжээгээр нэгдүгээрт орно. Хэрлэн гол Төв, Хэнтий, Дорнод аймгийн нутгийг дамжин урсаж улмаар улсын хилээс гадагш гарч Далай нуурт цутгана. Их Хэнтийн нурууны өвөр бэлээс эх авч урсах Богдын гол, Цагаан гол хоёрын уулзварыг Хэрлэн голын эх гэж үзнэ. Иймд улсын хил хүртэл 1090 километр урт, ус хураах сав газрын талбай 116.455 хавтгай дөрвөлжин километр бөгөөд усны дундаж унал километр тутамд 1.2 метр болно. Ингэхлээр Номхон далайн ай савын гол мөрний бүх талбайн 54%-ииг Хэрлэн голын усны сав эзлэх ажээ. Хэрлэн гол хэдийгээр өндөр уулнаас эх авч урсах боловч гурим байдал, хөндийн хэлбэр хэмжлийг харгалзан түүнийг талын голд хамааруулж болно. Голын хөндий дээд биедээ, тухайлбал Ширэгт голын билчэр хүртэл 0.7-0.9 километр өргөн, хажуу нь эгц, хад асга ихтэй байдаг. Харин Тэнүүн, Тэрэлж, Бүрх зэрэг томоохон голын уулзварт хөндийн ёроол 5-10 километр хүртэл уужирч ихээхэн намагжина. Хэрлэнгийн буудлаас доошлоход дахин 0.3-0.5 километр болтол нарийсавч уулнаас мултармагцаа даруй хээр талд орж 10-20 километр өргөн хөндийгөөр урсахдаа урсгалын хурд, унал эрс саарч нилээд тойрон тахирлахын (тахирлалын коэффициент 0.46) сацуу хэд хэд салаална.

Хэрлэн голын нийт уртад голын татам үзэгдэн түүний өргөн заримдаа 2-3 километр хүрч нуга намгийн өвслөг ургамал бут бургас ургах ба хуучин гулдирал, салаа татуурт хуваагджээ. Голын нийт уртад гулдиралын өргөн усны гүн, урсгалын хурд ихээхэн ялгаатай байна. Жишээлбэл: Хэрлэнгийн эхний хэсэгт гулдиралын өргөн 30- 50м, дунд, адаг хавьд 150- 200м болж 0.8- 1.5 метрийн гүн зонхилно. Урсгалын хурд уулсын хэсэгтээ 2 м/сек, нам тал газраа 1 м/сек болно. Голын үндсэн тэжээл нь хур бороо бөгөөд цас, гүний ус хоёр өчүүхэн (15-18 %) хувииг эзлэнэ. Олон жилийн ажиглалтаас үзэхэд усны түвшний хэлбэлзэл (хамгийн өндөр, хамгийн нам түвшний зөрүү) Хэрлэнгийн буудалд

343 м, Өндөрхаанд 250 м, Чойбалсан хотод 234 м байсан бөгөөд хамгийн өндөр түвшин зуны хур борооны үер буухад, хамгийн нам түвшин өвөл тохиолдоно. Иймд зөвхөн дулааны улиралд (5,6,7,8,9-р саруудад) бүх урсцын 80 гаруй хувь урсаж өнгөрдөг бөгөөд энэ баримт бол урсцын бүрэлдэн тогтоход хур борооны ус хичнээн их нөлөөтэйг харуулж байна. Нөгөө талаар бүх урсцын 30 гаруй хувийг хаврын үерийн ус эзэлнэ. Энэ нь Хэрлэнгийн савын уулт нутагт цас нилээд орж хайлахдаа усны урсцыг багагүй нэмэгдүүлдгийн баримт бизээ.

Хэрлэн гол уулнаас гарч хэдэн зуун километрийн турш элсэрхэг хөрс бүхий хээр тал дундуур урсдаг болохоор ууршуулах, шингээх зэргээр усаа алдаж урсац нь мэдэгдэхүйц татарч багасна. Зам зуурт Мөрөн, Цэнхэр, Аварга гэх мэт гол горхи цутгах боловч ууршилтыг нөхөж эс чадна. Хэрлэн гол ойт хээрийн бүсээс хуурай хээрийн бүсэнд шилжихдээ жилийн бүх урсцын 40-50 хувийг алддагийг харуулж байна. Усны дулааны горим ч гэсэн голын нийт уртад жигд биш, эхний хэсэг нь адгаасаа эрт хөлдөж орой гэсэх учраас хөлдүү байх хугацаа 1-2 долоо хоногоор илүү дутуу байх явдал ерийн хэрэг болно. Энэ нь юуны урьд өндөр уулын сэрүүн уур амьсгал, газрын гадаргын хэлбэр дүрсээс шалтгаалсан хэрэг бизээ.

Хэрлэн голын ус 10-р сарын сүүлчээр зайртаж, 11-р сарын эхээр хөлдөөд ихэвчлэн 4-р сарын сүүлчээр гэсч цэлмэнэ. Хавар бүр цөн түрэх боловч эрч хүч нь бага, тэгтлээ олон хоног үргэлжилдэггүй байна. Мөсний зузаан аль ч хэсэгтээ 1 метр орчим бөгөөд гүйхэн газраа ёроолгүй хөлдөж халиа тошин үүсгэх явдал тохиолдоно.

Хэрлэн голын сав: Хэрлэнгийн сав дахь усны гадаргаас уурших ууршилт Номхон далайн савд багтах голууд дотроо дээгүүр орно. Жишээлбэл: Аврагын голын цутгалан хувьд 5-р сард 170 см, талбайгаас уурших өдрийн дундаж ууршилт 150 см³, сарын дундаж 4500 см³ буюу 24 мм болж байв. Усны балансын ойролцоо тооцооноос үзэхэд Хэрлэнгийн савд жилд дунджаар 277 мм буюу 18.4 шоо дөрвөлжин километр хур бороо орох бөгөөд түүний дөнгөж 0.5 шоо дөрвөлжин километр голын урсцад, 17.9 шоо дөрвөлжин километр нь ус, хөрсний гадаргаас ууршихад зарцуулагддаг байна. Тэхдээ усны гадаргаас уурших ууршилтын явц дулааны улиралд хөрсний гадаргаас уурших ууршилтаас арай илүү байж болох юм.

Хэрлэн голын хатуу урсцын хэмжээ харьцангуй их байдгаараа бусад голуудаас эрс ялгагдана. Усны булингар Хэрлэн голоо уруудах тутамд нэмэгдэнэ. Энэ нь голын эхэнд усны эрозийн хүч илүү байдаг бол дунд ба адаг хавьд зөөвөрлөх ба тунаах явц голлодгоос шалтгаалдаг бизээ. Хэрлэн голд тунаадсын секундийн дундаж зарцуулга 18 кг хүрдэг явдал Ононгоос их болохыг нотлож байна.

Усны химийн бүтэц, нийт эрдэсжилт, улирал бүрд харилцан адилгүй бөгөөд голын уртад ч нилээд ялгаа гарна. Усны эрдэсжилт доошлох тутам нэмэгдэж байна. Энэ нь голын урсац уруудах тутамд багасаж гүний усны тэжээл нэмэгддэг зүй тогтоолтой холбоотой юм. Хэрлэн голын ус Дорнод хэсгийн бусад голын адил гидркарбонат-хлоридын ус бүхий гол мөрний ангилалд хамаарна. Энэ голд Онон мөрний адил Тул, Цурхай, Зэвэг, Хайруус, Алгана, Цулбуурт, Булуу цагаан, Гутаарь, Мөрөг жараахай зэрэг олон төрөл зүйлийн загаснууд амьдардаг.

Зураг-19. Хэрлэн голын ай сав.



Зураг-20. Гадаргын усны зураг.




2.6.2. Гүний усны нөөц.

Дэлгэрхаан сум нь Хэрлэн голын сав газарт хамаарагдана. Сумын нутаг дэвсгэр ерөнхийдөө гидрогеологийн хувьд Аварга багийн Хар тал, Долоод багийн Сүүжийн талууд нь доод цэрдийн хурдас дахь ус агуулсан бүрдлүүд буюу ан цав-нүх сүв-үеийн ба ан цав-үеүдийн төрлүүдийг агуулсан ус агуулсан бүрдлүүд байна. Ихэвчлэн шавар, шаварлаг занар, алевролит, элсэн чулуу, аргиллит, конгломерат, нүүрс, мергель, шохойн чулуу тархсан чөлөөт гадаргатай уст үе зарим газруудад 0-10 м-ийн гүнд, зарим газарт 10-50 м-ийн гүнд байна. Харин даралтат гадаргатай уст үе 10-50 м-ийн гүнд байрлах боломжтой ба ундаргыг 0.1-5 л/с байна гэж таамагласан байна. Хэрлэн голын хөндий болон уулсын бэл хормой нь гидрогеологийн бүрдлийн хувьд нүх-сүв үеүдэд агуулагдсан усжилттай ба ан цав-үеүдийн төрлүүдийг агуулсан горизонтоор ангилсан байна. Орчин үеийн, голын хурдас дахь ус агуулсан горизонтын ул хөрсний тархалт нь ихэвчлэн сайрга, элс, бул чулуу байх ба таамагласан ундарга 0.1-10 л/с гэж үзсэн байна.

Сумын уулархаг хэсгээр ихэвчлэн ан цав-судлын ба ан цавын төрлүүдийг агуулсан ан цавархаг чулуулаг дахь усжилттай бүрдлүүд зонхилох ба үндсэн чулуулгууд нь хүчиллэг ба дундлаг-боржин, боржин-порфир, боржин диорит боржин сиенит байх ба таамагласан ундарга 0,1-1л/с байна.

Газрын доорх усны илэрц болох зарим худаг цооног булгийн мэдээлэлд ихэвчлэн гидрокарбонат, гидрокарбонат-сульфатын төрлийн ус гэж үзүүлсэн байна.

Зураг-21. Гидрогеологийн зураг.



2.7. Инженер геологийн нөхцөл

2.7.1. Геологийн мужлал.

Дөрөвдөгчийн хурдас / Q_{IV} /. Орчин үеийн хурдас нь голын гулдрил ба татам, нуурын элс, шавар, хайргажин, элсэнцэр, шавранцар, давс бул чулуу, сэвсүүл элс хэлбэрээр алюви, алюви-пролювийн гарал үүсэлтэйгээр Хэрлэн голын хөндий, Аварга голын хөндий, Зүүн сайрын гол, Давст нуур орчимоор тархсан байна.

Дээд плейстоцен-глоцений / Q_{III} - Q_{IV} /. ангилагдаагүй хурдас нь нам дор уулсын бэл хормойгоор хайрга, хайрганцар, дайрга, дайрганцар, үйрмэг агуулсан шавранцар, элсэнцэр, элс хэлбэрээр делюви-солифлюкцийн, делюви-пролювийн, коллювийн гарал үүсэлтэйгээр деллюви-пролювийн ба нам дэнж бүхий алювийн талаар тархсан байна.

Дээд плейстоцен / Q_{III} /. нь Аваргын голын хөндий орчимоор пролювийн элс, бул чулуу, хайрга, хайрганцар, алевролит, нуур орчимоор нуур-мөстлөгийн элс хэлбэрээр гол-пролювийн, нуур-пролювийн гарал үүсэлтэйгаар тархсан байна.

Дунд-дээд дөрөвдөгчийн хурдас / Q_{II} - Q_{III} /. нь нуур-гол мөстлөгийн бул ба үхэр чулуу, хайрагжин элсэнцэр, шавранцар, шавар, алевролит хурдсаар алюви, аллюви-пролювийн гарал үүсэлтэйгээр Аварга багийн нутаг дэвсгэрт сумын төвийн хойд хэсэг болон алюви-пролювийн, делюви-пролювийн талуудад тархсан байна. Плиоцен-Доод дөрөвдөгчийн хурдас / βN_2 - Q_I /. голын хөндийд хүрмэн, хүрэм, андези-хүрэм, трахи-хүрэм хурдсаар Долоод багийн дэлгэрийн голын хөндийд тархсан байна.

Цэрдийн настай хурдас / Kz /. Аварга багийн урд хэсгээр болон сумын төвийн баруун хэсгээр Аварга болон Долоод багуудын зааг дээр Хөрзөн гравелит, элсжин, хайргажин, бул чулуу хэлбэрээр аллюви, аллюви-пролювийн гарал үүсэлтэйгээр тархсан байна. Зүүн баян формац / K_1zb /. Ангилаагүй хурдас нь Долоод болон Аваргын багуудын уулзвар болон Хэрлэн тооно багийн зүүн хэсэгт шавар, битумт, хуудасрхаг, шаварлаг занар, элжсин, алевролит, аргиллит, гравеллит хөрзөн, хүрэн нүүрс аллюви, аллюви-пролювийн гарал үүсэлтэйгээр нам доор уулсын тал хэсэгт зонхилон тархсан байна. Доод, вулканоген зузаалаг / K_1cb_1 /. хүрмэн чулуулаг хүрэм, андези-хүрэм, трахи-хүрэм, трахи-андези хүрэм, трахит хэлбэрээр Долоод багийн баруун хэсэг болон төв зүүн хойд хэсгээр тархсан байна.

Триас юрагийн хурдас / T_3 - J_1 /. дашбалбар формац трахи-хүрэм, трахиандези хүрэм, трахиандезит, тэдгээрийн бөсөл, ургамлын үлдэгдэл бүхий бөсөл-элсжин хэлбэрээр дэлгэр формац нь риолит, дацит, андезит, элсжин, алевро-элсжин, алевролит, хөрзөн, бөсөл-хөрзөн, ортофир, кварцит-порфир хэлбэрээр, ангилаагүй хурдас буюу андези хүрмэн, трахи хүрмэн, андезит, трахи андезит, трахит хэлбэрээр Долоод багийн зүүн урд хэсгээр уулархаг орчимд зонхилон тархсан байна.


Хануй формац /P₂hn₄/ нь Хэрлэнбаян-Улаан багийн баруун болон зүүн хойд сумын хил дагуу дөтгөөр буюу суурилаг эффузивын формац. Ургамлын үлдэгдэл бүхий бөсөллөг-тунамал ба тунамал чулуулгийн багц үеүүдийг агуулсан трахихүрэм, тархиандези-хүрэм, хүрэм-пантеллеритын найрлагатай бимодал эффузив чулуулгаар тархсан байна.

Их хар нуур формац /D₁ih/ нь Хэрлэн тооно багийн хойд хэсгээр элсжин, гравелит, шаварлаг занар хэлбэрээр тархсан байна. Хавчуу формац /D₁hv/ нь Хэрлэн тооно багийн төв хэсгээр элсжин, алевро-элсжин, алевролит, мөр хөлтөн бүхий шаварлаг занар, аргиллит, цахиурлаг чулуу, гравелит хэлбэрээр тархсан байна. Цариг гол формац /D₁hv/ нь Хэрлэнтооно багийн баруун урд хэсгээр шаварлаг занар, алевролит, элсжин, хөрзөн, шохойжин, мөр хөлтөн, далайн саргай бүхий гравеитийн мэшил хэлбэрээр тархсан байна.

Цэнхэр гол бүрдэл нь пироксен-эвэрхуурмагт габбро, габбро-диорит, эвэрхуурмагт-кварцат диорит хэлбэрээр Хэрлэнбаян-Улаан багийн баруун хойд хэсгээр тархсан байна. Ангилаагүй хурдас буюу кварц-серицитэт, кварц-хлорит-серицитэт занар, мета элсжин, кварцит, онколит бүхий шохойжин хэлбэрээр мөн хайчийн гол пироксент гнейс, мигматит, амфиболит, кварц-биотитот, хоёр гялтгануурт, эвэрхуурмагт талст занар, бал чулуу агуулсан гантиг чулуулгууд Хэрлэн тооно багийн хойд хэсэгт тархсан байна.

Бор-Өндөрийн бүрдэл нь Долоод болон Хэрлэнбаян-Улаан багийн уулзвар өндөрхөг уулархаг орчимд шүлдлэгдүү, ховроор эгирин-рибезитот, аляскитат, цайвар боржин чулуулгууд тархсан байна.

Зураг-22. Геологийн зураг.




2.7.2. Геоморфологийн тогтоц

Геоморфологийн тогтоцын хувьд Дэлгэрхаан сумын төв ба Аварга, Долоод багийн урд хэсгээр харьцангуй талархаг делюви-пролювийн тал, алюви-пролювийн тал, байнгын урсгалтай голын хөндийд голын татам бүхий алювийн тал, ангилагдаагүй татмын нам дэнж бүхий алювийн тал, түр зуурын урсгалтай голын хөндийд орчин үеийн татам, сайрын хөндий ба ёроол, тал байх ба гадаргын хэвгий 0-3 градус байна. Хэрлэнбаян-Улаан ба Аварга багуудын хойд хэсгээр гадаргын хэвгий нь 0-18 градус, ихээхэн хэрчигдсэн, хавтгай, бөмбөгөрдүү оройтой, эгц хажуутай дундаж өндөр уулс, дунд зэрэг хэрчигдсэн, эгцдүү хажуутай дундаж өндөр уулс, сул хэрчигдэлтэй хярласан үлдэц нам уулс, уулын амууд болон түр зуурын урсгалтай голын хөндий нь орчин үеийн татам, сайр ба ёроолын хөндийтэй байна. Мөн геологийн судалгаагаар тогтоогдсон ба орчин үед сэргэсэн хагаралууд ихтэй байна.

Хэрлэнтооно багийн нутаг нь ихэнхдээ гадаргын хэвгий нь: 0-18 градус, багийн хойд болон зүүн урд хэсгээр геологийн судалгаагаар тогоогдсон хэд хэдэн хагаралтай ихэвчлэн нуур-пролювийн тал, түр зуурын урсгалтай голын хөндийд орчин үеийн татам, сайрын хөндий, голын татам бүхий алювийн тал, багийн төв болон хойд хэсгээр дунд зэрэг хэрчигдэлтэй эгцдүү хажуутай эгцдүү хажуутай дундаж өндөр уулс, мөн дунд зэрэг хэрчигдсэн эгцдүү хажуутай нам уулс зонхилон тааралдана.

Зураг-23. Геоморфологийн зураг.




2.7.3. Цэвдгийн нөхцөл

Хэрлэнбаян-Улаан, Аварга, Долоод, Хэрлэн тооно багуудын урд хэсгээр олон жилийн цэвдэг чулуулаг тохиолдлын тархалттайгаар тархсан байна. Хэрлэнбаян-Улаан зүүн хэсэгт, Долоод болон Аварга багуудын хойд хэсгээр олон жилийн цэвдэг чулуулаг ховроор алаг цоог тархалттайгаар тархсан байх ба Хэрлэнбаян-Улаан Аварга багуудын хойд уулзвар хэсэгт олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тархалттайгаар тааралдана.


Хүснэгт-22. Сумын олон жилийн цэвдэгийн тархалт.

Д/д	Цэвдгийн тархалт	Талбай, га
1	Олон жилийн цэвдэг чулуулаг тохиолдлын тархалттай	302186.3
2	Олон жилийн цэвдэг чулуулаг ховор алаг цоог тархалттай	72916.6
3	Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тархалттай	8816.8

График-16. Сумын олон жилийн цэвдэгийн тархалтын эзлэх хувь.




Зураг-24. Цэвдгийн тархалтын зураг.



2.7.4. Газар чичирхийлэл

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум нь газар хөдлөлийн идэвхитэй бүсэд оршдог. Хэрлэнбаян-Улаан багийн хойт хэсэг болон Хэрлэн тооно багийн урд хэсгүүд нь 6 баллын газар чичирхийллийн мужид харин бусад буюу ерөнхийдөө сумын ихэнх нутаг дэвсгэр 9 баллын газар чичирхийллийн мужид хамаарагдаж байна. (MSK -64 шатлалын баллаар)

Зураг-25. Газар чичирхийллийн зураг.



ГУРАВ. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ

3.1. Түүхэн хөгжлийн тойм.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум нь 1754 онд Халхын Дорно замын баруун гарын дунд баруун этгээдийн хошуунаас тасалж байгуулсан. Манжийн ноёрхлын үед Халхын баруун гарын дунд өмнөд хошуу, 1912-1923 онд Сэцэн хан аймгийн Зоригт бэйсийн хошуу, 1924 оноос Хан хэнтий уулын аймгийн Дашбалбар уулын хошуу болж 1931 оны 4-р сарын 7-ны өдөр Дэлгэрхаан нэртэйгээр анх сум байгуулагджээ.

Энэ нутагт олон зууны туршид эртний сурвалжит Боржигон, Жүрхэн, Тайчууд зэрэг олон овог аймгууд зэрэгцэн оршиж ирсэн ба Чингис хааны дөрвөн хөлөг баатарын нэг Борохул, их жанжин Мухулай нар энэ нутагт төрж өссөн төдийгүй Монголын сэргэн мандал, хөгжил дэвшлийн томоохон төв болсон Монголын анхны нийслэл “Аураг” хот оршин байжээ.

Их эзэн богд Чингис хаан Монгол туургатныг нэгтгэх их аяны гарааг энэ нутгаас эхэлж түүнийг үр удам их хаан Өгөдэй, Мөнх, Есөнтөмөр зэрэг алтан ургийн хаадууд “Хэрэнгийн хөдөө арал”-д буюу их “Аураг” ордонд “Их Монгол Улс”-ын хааны ор сууринд сууцгааж байсан түүхтэй.

Мөн “Монголын нууц Товчоо” хэмээх түүх, уран зохиолын их өв сурвалж болсон хөнгөн судар энэ нутагт туурвигдаж мөн цэрэг, дайны догшин “Хар сүлд”-ийг мянган хээр азарганы хөхлөөр бүтээж “Шилэхэнцэг” буюу одоогийн Хэрлэн тооно ууланд тахин цэнгүүлж гурван голын Монголчууд Чингис хааны дайчин тугийн дор нэгдэж “Хамаг Монгол”-ын нэгдсэн Улсыг байгуулж бэхжүүлсэн түүхэн үйл явдлын гэрч болсон нутаг юм.

Энэ нутгийг Их эрдэмтэн Ардын уран зохиолч Цэндийн Дамдинсүрэн, Их номч Бямбын Ренчин, түүхч-археологич Эрдэмтэн доктор Хөдөөгийн Пэрлээ нар “Хөдөө арал”-ыг нэлэнхүйд нь судлан шинжилж, алтан ургийнхан төвлөрч байснаар барахгүй цэрэг, улс төрийн ажиллагааг удирдан явуулж байсан ба худалдаа арилжаа дэлгэрсэн, Их хаадын сүлд тахилгын сүмтэй тэр үеийн Монгол угсаатны томоохон төв байжээ гэдгийг тодорхойлжээ.

Мөн энэ нутгаас БНМАУ-ын Ерөнхий сайдаар ажиллаж байсан Хичээнгүй сайд Б.Цэрэндорж, Ардын журамт цэргийн анхны дөрвөн хороон даргын нэг партизан Б.Пунцаг, нэрт зохиолч, төр нийгмийн зүтгэлтэн М.Ядамсүрэн зэрэг алдартнууд төрөн гарсан байна.

3.2. Хүн ам зүй

3.2.1. Хүн амын тоо ба өрхийн байдал.

Дэлгэрхаан сум нь 2015 оны байдлаар 2345 хүн амтай бөгөөд 51.7 хувь нь эрэгтэйчүүд 48.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бол 100 эрэгтэйд 93 эмэгтэй оногдож байна. Хүн амын өсөлт 2010 оноос хойш бууралттай байсан бол 2015 онд өсөлт өмнөх оноос 5 хувиар өссөн байна.

Хүснэгт-23. Хүн ам, өрхийн тоо.

		2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Нийт	Тоо	2386	2376	2353	2473	2431	2390	2318	2291	2227	2345
	Өсөлтийн хувь	2	0	-1	5	-2	-2	-3	-1	-3	5
Хүйс	Эрэгтэй	1189	1206	1171	1220	1225	1199	1146	1140	1143	1210
	Эмэгтэй	1197	1170	1182	1253	1206	1191	1172	1151	1084	1129
	Харьцаа	101	97	101	103	98	99	102	101	95	93
Сумын төвийн иргэд		1553	1617	1585	1579	1551	1494	1481	1385	1282	1316
Хөдөө		786	759	768	894	882	891	837	906	945	1029
Хувийн жин	Сумын төвд	65.1	68.1	67.4	63.8	63.8	62.5	63.9	60.5	57.6	56.3
	Хөдөө	34.9	31.9	32.6	36.2	36.2	37.5	36.1	39.5	42.4	43.7

2015 оны эцсийн байдлаар хүн амын 56.3 хувь нь сумын төвд, 43.7 хувь нь хөдөө амьдарч байна. Хүн амын нягтаршилтаар 2015 онд 0.59 байна.

Хүснэгт-24. Хүн амын нягтшил.

Огноо	2011	2012	2013	2014	2015
Нягтшил	0.6	0.6	0.6	0.56	0.59

Хүснэгт-25. Өрхийн байршил ба ам бүл.

	2012	2013	2014	2015
Өрхийн тоо	697	696	709	740
Сумын төвийн өрх	418	394	394	397
Хөдөөгийн өрх	279	302	315	343
Нэг өрхөд оногдох ам бүл				
Сумын дундаж	3.3	3.3	3.1	3.2
Сумын төвийн өрх	3.5	3.5	3.3	3.3
Хөдөөгийн өрх	3.0	3.0	3.0	3.0

Сумын нийт өрхийн тоо 740 байгаа бөгөөд үүнээс 397 өрх сумын төвд, 343 өрх хөдөөд амьдардаг. Дэлгэрхаан сумын нэг өрхөд ноогдох хүн амын тоогоор 3.2 хүн ноогдож байгаа бол хөдөөгийн өрхөд 3.0 хүн харин төвийн өрхөд 3.3 хүн ноогдож байна.

Хүснэгт-26. Хүн амын ердийн цэвэр өсөлт.

	Он				
	2010	2011	2013	2014	2015
Нийт хүн ам	2431	2390	2291	2227	2339
Төрсөн хүүхэд	49	58	50	51	53
Нас барсан иргэд	5	5	18	11	17
Ердийн цэвэр өсөлт	44	53	32	40	36
Өсөлт хувь	1.8	2.2	1.4	1.8	1.5

Тус суманд сүүлийн таван жилд 50 гаруй хүүхэд шинээр төрж, 10 гаруй хүн нас барж ердийн цэвэр өсөлт 30-50 гаруй буюу 1.4-2.2 хувиар өссөн байна.

Хүснэгт-27. Хүн амд хөдөлмөрийн насны хүмүүсийн эзлэх хувь.

Нийт хүн амын тоо		Үүнээс: насны бүлэг					Хөдөлмөрийн насны хүн ам
		0-14	15-29	30-54	55-69	70+	
2014	2227	676	580	749	171	51	1329
Эзлэх хувь	100	30.4	26.0	33.6	7.7	2.3	59.7
2015	2339	743	570	796	179	51	1366
Эзлэх хувь	100	31.8	24.4	34.0	7.7	2.2	58.4

2015 оны байдлаар нийт хүн амын 58.4 хувь нь хөдөлмөрийн насны хүн, 31.8 хувь нь хүүхэд, 9.9 хувь нь тэтгэвэрийн насны хүмүүс байна. Өмнөд онтой нь харьцуулбал хөдөлмөрийн насны хүний эзлэх хувь 1.3 хувиар буурсан байна.

Хүснэгт-28. Эмзэг бүлгийн хүн амын тоо ба эзлэх хувь.

Эмзэг бүлгийн иргэдийн тоо	Он			
	2010	2011	2012	2013
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	78	76	85	84
Хүн амд эзлэх хувь	3.2	3.2	3.7	3.7
Үүнээс эмэгтэй	33	31	35	35
Эмэгтэйчүүдэд эзлэх хувь	2.7	2.6	3.0	3.0
Өнчин хүүхдийн тоо	48	53	55	56
Бүтэн өнчин хүүхэд		1	1	1
Хагас өнчин	48	52	54	55
Нийт дүн	126	129	140	140
Нийт хүн амд эзлэх хувь	5.2	5.4	6.0	6.1

2013 оны нийт хүн амын 84 хүн буюу 3.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ба эдгээрийн 35 хүн нь эмэгтэй буюу сумын нийт эмэгтэйчүүдтэй харьцуулбал 3 хувийг эзэлж байна. Мөн тус суманд өнчин хүүхдийн тоо нь 56 байгаагийн 1 нь бүтэн өнчин 55 нь хагас өнчин хүүхэд байна. Эмзэг бүлгийн хүн ам нийт хүн амд 6.1 хувийг эзэлж байгаа.

3.2.2. Хүн амын амьжиргааны түвшин ба орлого

Хүн амын амьжиргааны түвшинг судалгаагаар дараах судалгааг гаргалаа. Нийт орон сууцны зориулалттай 606 сууц байгаагаас 525 гэр, 75 нь байшинд, 6 нь зориулалтын бус сууцанд амьдардаг байна.

Хүснэгт-29. Сумын өрхийн тоо, сууцны төрлөөр.

Байршил	Бүгд	Үүнээс		
		Гэр	Байшин	Зориулалтын бус
Нийт	606	525	75	6

Байшинд амьдардаг өрхүүд 100 хувь амины буюу өөрийн сууцтай байранд амьдарч байна. Тус сумын иргэдийн ихэнх нь амины орон сууцанд амьдардаг онцлогтой юм.

Мөн өрхийн амьжиргааны түвшинг илэрхийлэх нэг үзүүлэлт бол хуримтлал юм.

Хүснэгт-30. Хадгаламжийн хэмжээ сая төг¹.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013	2014
Нийт хадгаламж	Сая төг	252.7	344.9	540.3	770.6	953.1
Хугацаатай	Сая төг	183.1	253.5	365.8	640.4	834.6

¹ ҮСХ, Хэнтий аймгийн статистик 2015 он


Хугацаагүй	Сая төг	69.7	91.5	174.5	130.3	118.5
Нэг хүнд оногдох	Мян төг	103.9	144.3	233.1	336.4	428.0
	Өсөлтийн хувь		38.8	61.5	44.3	27.2

2014 оны эцсийн байдлаар сумын нэг хүнд 428.0 мянган төгрөгийн хадгаламж ноогдож байгаа нь өмнөд оноос 27.2 хувиар өссөн байна. Сүүлийн 5 жилүүдийн судалгааг харбал жилээс жилд нэмэгдсэн байна.

Хүснэгт-31. Нийт зээлийн өрийн үлдэгдэл сая төг.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013	2014
Зээлийн өрийн үлдэгдэл	Сая төг	499.4	911.2	1179.6	1622.1	2243.8
	Мян төг	205.4	381.3	508.9	708.0	1007.5
Нэг хүнд оногдох	Өсөлтийн хувь		85.6	33.5	39.1	42.3

Зураг-26. Хүн ам зүйн зураг /Насны бүлгээр/.



3.3. Хөдөө аж ахуйн салбар

3.3.1. Мал аж ахуйн салбар

Сумын эдийн засгийн суурь бөгөөд гол салбар нь мал аж ахуйн салбар. Сумын нийт өрхийн 46.4 хувь буюу 343 өрх айл мал аж ахуй эрхлэн амьдардаг.


2015 оны эцсийн тооллогоор 229609 толгой мал тоолуулсаны 79 тэмээ, 15405 адуу, 10814 үхэр, 106224 хонь, 97087 нь ямаа.

Хүснэгт-32. Малын тооны өсөлт.

он	Малын нийт тоо	Үүнээс				
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
толгойн тоо						
2015	229609	79	15405	10814	106224	97087
2014	202408	67	13478	9031	94930	84902
2013	178544	67	11098	6838	83286	77255
2012	154609	90	9143	5284	74874	65218
2011	134963	84	7779	4183	64124	58793
Өсөлтийн хувь						
2015	13.4	17.9	14.3	19.7	11.9	14.4
2014	13.4	0.0	21.4	32.1	14.0	9.9
2013	15.5	-25.6	21.4	29.4	11.2	18.5
2012	14.6	7.1	17.5	26.3	16.8	10.9

Сүүлийн 5 жилийн байдлаар малын дундаж өсөлт 13-15 хувиар өссөн ба 2013 онд хамгийн өндөр буюу 15.5 хувиар өссөн байна. 2015 онд нийт малын дундаж өсөлт 13.4 хувиар өссөн бол тэмээ 17.9 хувь, адуу 14.3 хувь, үхэр 19.7 хувь, хонь 11.9 хувь, ямаа 14.4 хувиар тус тус өссөн байна.

График-17. Малын динамикаар.



Хүснэгт-33. Малын бүтэц ба өөрчлөлт.

Огноо	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2015	0.03	6.7	4.7	46.3	42.3
2014	0.03	6.7	4.5	46.9	41.9
2013	0.04	6.2	3.8	46.6	43.3
2012	0.06	5.9	3.4	48.4	42.2
2011	0.06	5.8	3.1	47.5	43.6

2015 оны эцсийн нийт малын 46.3 хувийг хонь, 42.3 хувийг ямаа, 6.7 хувийг адуу, 4.7 хувийг үхэр, 0.03 хувийг тэмээ эзэлж байна. 2015 оны сүргийн бүтцийг 2014 онтой харьцуулахад нийт мал эзлэх тэмээ, адуу хэвийн үхэр 0.2 хувиар, ямаа 0.4 хувиар, өссөн бол хонь 0.6 хувиар буурсан хандлагатай байна.

МАА-н чанарын үзүүлэлт болгон бойжуулсан төл, зүй бусын хорогдлын үзүүлэлтийн сүүлийн 3 жилийн байдлаар авч үзлээ.

Хүснэгт-34. Сумын бойжуулсан төл.

Баг нэр	Төрөл	Дундаж	2015	2014	2013	2012
Хэрлэнбаян-Улаан	Бойжуулсан ботго	7	7	2	13	7
	Бойжуулсан унага	668	855	735	645	437
	Бойжуулсан тугал	814	1149	931	670	504
	Бойжуулсан хурга	8076	10946	8459	7214	5683
	Бойжуулсан ишиг	8517	11068	10914	6870	5215
Долоод	Бойжуулсан ботго	1	2	1	2	0
	Бойжуулсан унага	582	712	622	533	459
	Бойжуулсан тугал	460	628	530	380	303
	Бойжуулсан хурга	8401	9303	8170	6982	9147
	Бойжуулсан ишиг	6752	7567	6736	5729	6975
Аварга	Бойжуулсан ботго	1	1	0	0	2
	Бойжуулсан унага	526	651	554	486	414
	Бойжуулсан тугал	607	768	671	564	425
	Бойжуулсан хурга	6851	7639	6620	7524	5621
	Бойжуулсан ишиг	5861	6801	5659	6373	4612
Хэрлэн тооно	Бойжуулсан ботго	12	10	2	7	29
	Бойжуулсан унага	961	1079	902	826	1037
	Бойжуулсан тугал	665	775	712	614	558
	Бойжуулсан хурга	10205	7639	9791	11977	11412
	Бойжуулсан ишиг	9282	11440	7715	9819	8152
Сумын нийт	Бойжуулсан ботго	21	20	5	22	38
	Бойжуулсан унага	2737	3297	2813	2490	2347
	Бойжуулсан тугал	2546	3320	2844	2228	1790
	Бойжуулсан хурга	34352	38808	33040	33697	31863
	Бойжуулсан ишиг	30411	36876	31024	28791	24954

2011-2015 оны дундажаар нийт 70067 төл бойжуулсан бөгөөд 2015 онд хамгийн эх төл буюу 82321 төл бойжуулсанаас 20 ботго, 3297 унага, 3320 тугал, 38808 хурга, 36876 ишиг бойжуулсан байна.

Хүснэгт-35. Зүй бусын хорогдлын тоо /мян,тоо/.

Баг нэр	Төрөл	2015	2014	2013	2012
Хэрлэнбаян-Улаан	Адуу	0.001	0.030	0.000	0.003
	Үхэр	0.002	0.008	0.000	0.010
	Тэмээ	0.000	0.000	0.000	0.000
	Хонь	0.015	0.473	0.000	0.038
	Ямаа	0.024	0.710	0.000	0.017
Долоод	Адуу	0.006	0.017	0.001	0.003
	Үхэр	0.025	0.013	0.003	0.032
	Тэмээ	0.000	0.000	0.000	0.000
	Хонь	0.206	0.075	0.169	0.245
	Ямаа	0.204	0.074	0.036	0.041
Аварга	Адуу	0.051	0.033	0.018	0.011
	Үхэр	0.061	0.020	0.041	0.005
	Тэмээ	0.001	0.002	0.001	0.000
	Хонь	0.947	0.461	0.678	0.171
	Ямаа	0.719	0.460	0.501	0.204
Хэрлэн тооно	Адуу	0.025	0.035	0.014	0.018
	Үхэр	0.014	0.027	0.016	0.006
	Тэмээ	0.000	0.001	0.000	0.002
	Хонь	0.241	0.524	0.237	0.247
	Ямаа	0.152	0.471	0.182	0.371
Сумын нийт	Адуу	0.083	0.115	0.033	0.035
	Үхэр	0.102	0.068	0.060	0.053
	Тэмээ	0.001	0.003	0.001	0.002
	Хонь	1.409	1.533	1.084	0.701
	Ямаа	1.099	1.715	0.719	0.633
	Нийт	2.694	3.434	1.897	1.424


2015 онд 2.694 мян.тоо толгой мал зүй бус хорогдолоор хорогдсон бөгөөд адуу 0.083 мян.тоо, үхэр 0.102 мян.тоо, тэмээ 0.001 мян.тоо, хонь 1.409 мян.тоо, ямаа 1.099 мян.тоо толгой мал тус тус хорогдсон байна. Энэ хорогдсон нь 2014 оноос 21.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2014 онд хамгийн их зүй бус хорогдолт гарсан 3.434 мян.тоо толгой мал хорогдсон нь өмнөх оноос 81 хувиар эрс их хэмжээгээр өссөн сөрөг хандлагатай байсан байна.

Хүснэгт-36. Өвчнөөр хорогдсон малын тоо.

Баг нэр	Төрөл	2014	2013	2012
Хэрлэнбаян-Улаан	Адуу	29		
	Үхэр	6		5
	Тэмээ			
	Хонь	472		13
	Ямаа	710		17
Долоод	Адуу	15		
	Үхэр	10		4
	Тэмээ			
	Хонь	57		79
	Ямаа	45		31
Аварга	Адуу	0	4	2
	Үхэр			
	Тэмээ		1	
	Хонь		169	10
	Ямаа		125	14
Хэрлэн тооно	Адуу	15	7	15
	Үхэр	7		
	Тэмээ			2
	Хонь	259	90	46
	Ямаа	164	53	42
Сумын нийт	Адуу	59	11	17
	Үхэр	23	0	9
	Тэмээ	0	1	2
	Хонь	788	259	148
	Ямаа	919	178	104
	Нийт	1789	449	280

Том малын зүй бус хорогдол сүүлийн жилүүдэд эхсэх хандлагатай байна. 2012 онд 280 толгой мал зүй бус хорогдоллор хорогдсон бол 2013 онд 449 толгой буюу өмнөх оныхоос 1.6 дахин ихссэн бол 2014 онд энэ тоо 1789 болголоо өссөн бөгөөд энэ нь өмнөх оноос бараг 4 дахин ихссэн сөрөг талтай байна.

Зураг-27. Мал сүлгийн бүтэц.



3.3.2. Малчин өрхийн малын тоо ба соёл ахуйн зарим үзүүлэлт

Малчин өрхийн амьжиргааг тодорхойлох нэг үзүүлэлт бол малын тоо бөгөөд нэг малчин өрхөд оногдох малын тоо юм.

Хүснэгт-37. Сум, багийн малын тоо.

Огноо	Төрөл	Хэрлэнбаян-Улаан	Долоод	Аварга	Хэрлэн тооно	Сумын нийт
2012	Адуу	1965	2072	1777	3329	9143
	Үхэр	1481	879	1311	1613	5284
	Тэмээ	53	2	9	26	90
	Хонь	17620	17448	16484	23322	74874
	Ямаа	17217	13958	15413	18630	65218
	Нийт	38336	34359	34994	46920	154609
2013	Адуу	2803	2322	2077	3896	11098
	Үхэр	2011	1125	1727	1975	6838
	Тэмээ	20	8	9	30	67
	Хонь	21332	18837	18186	24931	83286
	Ямаа	24781	15837	16178	20459	77255
	Нийт	50947	38129	38177	51291	178544
2014	Адуу	3227	3061	2567	4623	13478
	Үхэр	2886	1708	2135	2302	9031
	Тэмээ	21	9	8	29	67
	Хонь	25190	22325	19823	27562	94900
	Ямаа	26751	18675	17973	21533	84932
	Нийт	58075	45778	42506	56049	202408
2015	Адуу	4063	3217	2909	4929	15118
	Үхэр	3912	1922	2440	2444	10718
	Тэмээ	23	12	8	36	79
	Хонь	34239	24240	19777	27968	106224
	Ямаа	34746	20510	18957	22874	97087
	Нийт	76983	49901	44091	58251	229226

Хүснэгт-38. Малчин өрхөд оногдох малын тоо.

Малчин өрх		2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
		253	256	298	294	297	279	302	315	343
Малын тоо		163499	168231	127952	127353	134963	154609	178544	202408	229609
Нэг өрхөд ноогдох малын тоо		646	657	429	433	454	554	591	643	669
Өөрчлөлт	Тоо	89	11	-228	4	21	100	37	51	27
	Хувь	15.9	1.7	-34.7	0.9	4.9	21.9	6.7	8.7	4.2

Тус сумын нэг малчин өрхөд оногдох малын тоог сүүлийн 10 жилээр авч үзвэл 2007 онд 646 толгой мал оногдож байсан бол 2009-2011 онуудад хамгийн бага буюу 429-454 толгой мал оногдож байжээ харин 2015 оны байдлаар нэг малчин өрхөд 669 толгой мал оногдож байгаа нь өмнөх өнийхоос 27 толгойгоор их буюу 4,2 хувиар нэгдсэн байна.

Хүснэгт-39. Эрчим хүчний эх үүсвэр оролцогчдын хувиар.

Огноо	Цахилгааны эх үүсгүүр			
	Нарны	Салхины	Бага оврын цахилгаан	Төвлөрсөн систем
2012	234	2	3	-
2013	257	2	5	1
2014	249	-	10	3
2015	301	3	26	1

Дэлгэрхаан сум болон Хэрлэн баян Улаан баг нь нь эрчим хүчний төвийн нэгдсэн сүлжээнд холбогдсон. Харин малчин өрхүүд цахилгааны эх үүсвэрээ өөрсдөө нар, салхи, бага оврын цахилгааны эх үүсвэрүүдээ хангаж байна. 2015 оны байдлаар 331 цахилгааны эх үүсвэрүүдээс 301 нь нарны эх үүсвэрээр хангагдаж байна.

Хүснэгт-40. Малчин өрхийн ахуйн зарим үзүүлэлтүүд.

Огноо	Сансарын антенн	Телевизор	Радио	Оёдлын машин	Гар утас
2012	211	215	144	189	281
2013	174	226	165	195	230
2014	202	220	132	188	264
2015	250	264	174	222	313

Нийт хөдөөгийн малчин өрхийн ахуйн зарим үзүүлэлтүүдийг сүүлийн 4 жилийн харьцуулбал жилээс жилд нэмэгдсэн байна.

Хүснэгт-41. Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан байдал.

	2015	2014	2013	2012	2011	2010
Даатгалд хамрагдсан өрх	132	63	84	84	73	100
Даатгуулсан малын тоо	24632.0	16486.0	14965.0	15010.0	15486.0	20129.0
Хураамжийн орлого	17168.0	6863.5	9170.1	8203.9	6125.6	7815.4

3.3.3. Газар тариалан

Газар тариалан эрхлэх зориулалтаар 3359 га талбайд 26 иргэн аж ахуй нэгж байгаа бөгөөд үүнээс 27 өрх, 9 ААН үйл ажиллагаа явуулж байна. 208.2 га талбайд уранш, 2643 га талбайд тариалалт, 140 га талбайг өнжөөсөн байна.

Хүснэгт-42. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тариалсан талбай /га/.

№	Аж Ахуй нэгжийн нэр	Нийт тариалангийн талбайн хэмжээ га-гаар
1	балхэМонгол ХХК	2400
2	АДОТААЗахиргаа	80
3	Хөдөө арал ХХК	10
4	ЗХ 232-р анги	2
5	Астрарүүт ХХК	150
6	Дэвшилтэд технологи иноваци судлалын нэвтрүүлэх төв	100
7	Иннова Ложистик ХХК	10
8	Хөлөг од ХХК	200
9	А.Батхүү	200
10	Д.Хүрэлбаатар	10
11	С.Нямсайхан	10

12	Г.Уранчимэг	270
13	Н.Сайнбилэг	30
14	С.Даваа	5
15	Ц.Балдандорж	5
16	Ч.Гантөмөр	1
17	С.Ганбат	2
18	Д.Урангоо	1
19	Б.Аахүү	1
20	Н.Туяа	5
21	Ц.Сүнсэлтуяа	2
22	Д.Лувсанбалдан	2
23	Б.Машлай	1
24	П.Хасбаатар	1
25	Б.Мөнцэцэг	1
26	Эмийн ургамал тарималжуулалтын холбоо	60

Хүснэгт-43. 2014 онд хураан авсан ургацын хэмжээ.

Төрөл		2014
Төмс		0.033
Бэлтгэсэн өвс		1.728
Гар тэжээл		0.003
Хужир шүү		0.09
Эмийн ургамал		0.16
Хүнсний ногоо- Бүгд	байцаа	0.001
	лууван	0.002
	шар манжин	0.002
	сармис	0.002
	өргөст хэмх	0.001

Сумын хэмжээгээр жилд 0.006мян.га талбайд төмс, 0.004 мян.га талбайд хүнсний ногоо тариалж 0.0006 мян.кг төмс, 0.0008 мян.кг хүнсний ногоо хураан авсан.

3.4. Аж ахуй нэгж

Дэлгэрхаан суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагыг сүүлийн 5 жилээр авч үзвэл 2011 онд 33 аж ахуй нэгж байсан бол 2012 онд энэ тоо буурч 28 болсон байна. Харин 2015 онд 93 аж ахуй нэгж байгаагаас 79 нь хувийн хэлбэрийн 10 нь төрийн өмчийн, 4 нь орон нутгийн өмчийн хэлбэрийн аж ахуй нэгж үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт-44. Аж ахуй нэгжийн өмчийн хэлбэр.

Өмчийн хэлбэр	2015	2014	2013	2012	2011
Төрийн өмчийн	10	7	7	7	7
Хувийн	79	24	20	17	22
Орон нутгийн өмчийн	4	3	3	4	4
Бүгд	93	34	30	28	33

Тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжийн салбараар нь авч үзвэл 8 нь эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа явуулдаг, 7 нь бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоцикл, түлш, шатахууны худалдаа, засвар үйлчилгээ үзүүлдэг, 4 нь боловсролын салбарын үйл ажиллагаа болон зочид буудал, зоогийн газар байна.

Хүснэгт-45. Аж ахуй нэгжийн тоо.

Байгууллагууд	2015	2014	2013	2012	2011
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	3	3	-	0	2
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоцикл, түлш, шатахууны худалдаа, засвар үйлчилгээ	7	8	8	9	11
Зочид буудал, зоогийн газар	4	4	5	5	4
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	2	1	-	0	0
Санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	-	-	-	0	1
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	1	1	1	1	1
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан	3	3	3	3	3
Боловсролын салбарын үйл ажиллагаа	4	4	4	4	4
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	8	8	6	5	5
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	2	2	3	1	2
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	-	-	-	0	0
Нийт	34	34	30	28	33

3.6. Банк санхүү

Суманд ХААН болон ТӨРИЙН банкны тооцооны төвүүд ажиллаж үйл ажиллагаа явуулж иргэдэд үйлчилж байна.

Хаан банк: Тус банк нь 1991 оны 09-р сарын 01-ний өдөр Хэнтий аймаг дахь Хаан банк нь Хөдөө Аж Ахуйн хоршоолол банк нэртэйгээр анх байгуулагдаж байсан. Дэлгэрхаан тооцооны төв нь 1494-н харилцагч иргэдтэй, 442 хадгаламж эзэмшигчтэй, Харилцагч байгууллагатай, 405 зээлдэгчтэй ажилтнуудаараа дамжуулан харилцагчиддаа банк санхүүгийн үйлчилгээ үзүүлж байна.

Төрийн банк: Дэлгэрхаан тооцооны төв нь 2007 оны 01 сарын 01-нд “Монгол шуудан банк” нэртэйгээр 3 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа эхэлж байсан. 2010 онд 725 харилцагчтай, зээлийн багц 70.153 мянган төгрөг, татан төвлөрүүлсэн. Хөрөнгө 11.824 мянган төгрөг, Хүүгийн бус орлого 816 мянган төгрөг, хүүгийн орлого 3353 мянган төгрөг байсан бол банк үйл ажиллагааны цар хүрээ өргөжин тэлж 4053 харилцагчтай, 314 зээлдэгчтэй, зээлийн багц 648.08 мянган төгрөг, татан төвлөрүүлсэн хөрөнгө 267.496 мянган төгрөг, хүүгийн бус орлого 4559 мянган төгрөг, хүүгийн орлого 47.288 мянган төгрөг болон өсөж зах зээл эзэлж ТТХөрөнгөөр 15.61% зээлийн багу 63.8% эзлэж байна.

Хүснэгт-46. Хадгаламжийн хэмжээ сая төг.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013	2014
Нийт хадгаламж	Сая төг	252.7	344.9	540.3	770.6	953.1
Хугацаатай	Сая төг	183.1	253.5	365.8	640.4	834.6
Хугацаагүй	Сая төг	69.7	91.5	174.5	130.3	118.5
Нэг хүнд оногдох	Мян төг	103.9	144.3	233.1	336.4	428.0
	Өсөлтийн хувь		38.8	61.5	44.3	27.2

2014 оны эцсийн байдлаар сумын нэг хүнд 428.0 мянган төгрөгийн хадгаламж ноогдож байгаа нь өмнөд оноос 27.2 хувиар өссөн байна. Сүүлийн 5 жилүүдийн судалгааг харбал жилээс жилд нэмэгдсэн байна.
Ямааны махыг бусад малын махны адил хүнсэнд хэрэглэдэг ба онцлог нь ямаа мах булчиндаа гадар өөх багатай, өөхөн сүүлгүй, харин дотор өөхний хуримтлал ихтэй, ямааны мах өөхний нядлагын гарц 40-45 хувь байдаг. Ямааны өлөн гэдэс хиамны үйлдвэрийн чухал түүхий эд болох ба эврээр нь жижиг сам, цаасны хутга зэрэг эдлэл, туурайгаар нь цавуу хийдэг байна. Ямааны ясаар янз бүрийн ясан эдлэл хийж болохоос гадна нунтаглаж малын тэжээлийн хольц, газар тариалангийн сайн бордоо бэлтгэдэг.

Ямааны маханд нийтдээ 15 нэрийн аминхүчил илэрсэн ба борог маханд агуулагдах үл орлогдох амин хүчлийн хэмжээ өөхтэй махныхаас харьцангуй их тодорхойлогдсон байна. Ямааны мах олон нэрийн хүчлээр баялаг, ханаагүй тосны хүчлийн агууламж өндөн (45.7-49.1%) төдийгүй уургийн үл орлогдох амин хүчил (44.0-39.0%) ихтэй чанартай мах хэмээн тодорхойлжээ (Л.Чой-Иш, 2005).

Монгол ямаа бэлчээрээр таргалах чадвар сайтай бөгөөд намар бvдvвн ухна 55-58, эм ямаа 37-41, шvдлэн ухна 35-38, охин шvдлэн 29-31 кг жин дардаг.

Хүснэгт-79. Ямааны махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцож гаргавал дараах байдалтай байна.

Нас	Амьдын жин	Гулуузын жин	Нядлагын		Малын нэмэгдэх махны хэмжээ /кг/	Малын тоо	Нийт нэмэгдэх махны хэмжээ /кг/
			жин	хувь			
1.5	36.9	16.0	18.3	47.6	1.7	26213	44562.1

2.5	42.9	19.1	21.1	49.6	2.5	9709	24272.5
3.5	48.9	22.0	24.7	49.5	7.5	27184	203880.0
Хээлтүүлэгч	52.2	24.7	26.9	49.1	11.4	485	5529.0
Хээлтэгч	37.9	14.1	16.0	50.4	6.5	33495	217717.5
Бүгд						97087	495961.1

Дээрх хүснэгтээр тооцсон махыг ямаан толгойд шилжүүлвэл дараах томъёогоор тооцно.

$$T_x = \frac{A_{\text{Шмах}} + (A_{\text{Шмах}} * НГх)}{АЖэ/х}$$

T_x - ямааны тоо,

$A_{\text{Шмах}}$ - махан ашиг,

$НГх$ - нядалгааны гарцыг өсгөх хэмжээ ($\frac{46}{100} = 0.46$),

$АЖэ/х$ - ямааны амьдын жин /дундажаар/

$$T_x = \frac{495961.1 + (495961.1 * 0.46)}{43.8} = 16532$$

Ямааны сүүний ашиг шимийг Д.Цэрэнсодном нэлээд сайн судалж, говийн нөхцөлд ямааны саалын хугацаа 225 хоног үргэлжилж, 60-70 литр сүү саалгадаг, сүүний гарц саалийн эхэн үед бага, дунд үеэр ихсэж, сүүл үе рүүгээ дахин багасдаг, харин ямааны сүүний гарц зургаа, долдугаар саруудад ихсэж, дээд хэмжээндээ хүрэх ба хоногийн саам 108-412 гр, сарынх 3.24-12.36 литр хүрнэ. Р.Индра нарын судалгаагаар говийн ямааны сүүний хуурай бодис 15.44-0.06 хувь, тос 5.81-0.03 хувь, нийт уураг 3.87-0.03 хувь, лактоз 4.87-0.29 хувь, үнс 0.89-0.019 хувь байжээ.

Ямааны саалийн хугацаа 7 сар үргэлжилж, 60-70 литр сүү өгдөг. Сүү ашиглах гол үе нь 6-р сарын 1-нээс 8-р дугаар сарын 15-ныг хүртэлх хугацаа бөгөөд ямаа бүрээс таваарын 20-30 литр сүү ашиглана.

Хүснэгт-80. Ямааны сүү бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцно.

Хүйс	Тоо, толгой	Нэгжээс авах сүү /л/	Бүгд /л/
Эм ямаа	33495	25	837375

Ямаан сүргийн тархалт дэлхийн өндөр уудам нутгийг хамрах учир тухайн улс орны цаг агаарын эрс халуун эсвэл бүр сэрүүн байдлаас хамаарч ямаа элгэн халцгай эсвэл хэт ноосорхог, зарим нь ноолууртай байдаг. Нэг ямаанаас дунджаар 250 грамм ноолуур гардаг. Нэг грамм цэвэр ноолуураар 9-10 метр утас ээрдэг. Монгол улс нь дэлхийн нийт ноолуурын 35-40% гаруй хувийг бэлтгэдэг. Монгол ямааны ноолуурын ширхэгийн голч 13.0-16.5 мкм дундаж урт 38-45 мм бөгөөд монголын эрс тэс цаг ууртай холбогдон дулаан хадгалах чанараараа бусад орны ямааны ноолуураас давуу байдаг. Ямааны ноолууран бүтээгдэхүүн нь хөнгөн, уян зөөлөн, дулаан хадгалах болон хэлбэрээ хадгалах чадвар онцгой сайн, тансаг бүтээгдэхүүн бөгөөд зах зээлд байнгын эрэлт хэрэгцээтэй байдаг.

Ухна 250-350, эм ямаа 240-270, борлон ухна 200-240, охин борлон 200-230, эр ямаа 240-380 гр ноолуур өгдөг.

Хүснэгт-81. Ямааны ноолуур бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцно.

№	Нас	Тоо, толгой	Нэгжээс авах ноолуур /кг/	Бүгд /кг/
1	1.5	26213	0.19	4980.5
2	2.5	9709	0.21	2038.9
3	3.5	27184	0.30	8155.2
4	Хээлтүүлэгч	485	0.35	169.8
5	Хээлтэгч	33495	0.22	7368.9
Бүгд		97087		22713.2

Арьс нэхий, дайвар бүтээгдэхүүн /толгой, цувдай, өлөн/ бий болгох чадавхи нь дээрх хүснэгтэнд тооцсон нийт ямаан сүргийн тоотой тэнцүү 97087 байна.

2015 оны эцсийн байдлаар Дэлгэрхаан сумын нийт ямаан сүргийн ашиг шимийг мах, сүү, ноолуур, арьс, дайвар бүтээгдэхүүнээр тооцож үзэв.

Хүснэгт-82. Бэлчээрийн газрын газрын бүтээгч чадавхийг дараах хүснэгтээр тооцов.

Мах			Сүү			Ноолуур			Арьс			Дайвар бүтээгдэхүүн			Бүгд дүн /төг/
Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /л/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	
16532.0	3900.0	64474800.0	837375.0	800.0	669900000.0	22713.2	55000.0	1249226000.0	97087.0	8000.0	776696000.0	97087.0	1500.0	145630500.0	2905927300.0

Дээрх хүснэгтээс харахад Дэлгэрхаан сум нь 360996.97 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхи 2905927300 төгрөг болж байна.

Эндээс 1 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээг дараах томъёогоор тооцож үзвэл

$$БЧга = \frac{БЧ}{S} = \frac{2905927300 \text{ төг}}{360996.97 \text{ га}} = 8049.7 \text{ төгрөг}$$


4.3.3. Түүх соёлын дурсгалт газар



Дэлгэрхаан сумын нийт нутаг дэвсгэр нь бүхэлдээ домогт “Хэрлэний хөдөө арал” юм. Энэ нутагт Монголын анхны нийслэл их “Аураг” хотын балгас, нууц товчооны 750 жилийн ойд зориулсан гэрэлт хөшөө зэрэг биет дурсгал байхаас гадна Монголын бүх цэргийн хар сүлд энэ нутагт бүтээгдэн залагдсан, Алтан ургийн томоохон хаадууд хаан ширээнд суусан, Хулан хатан, Тулуй эзэн, Өндөр гэгээн Занабазар зэрэг түүхэн хүмүүстэй холбоотой газар нутаг, уул ус олон байдгаас гадна нууц товчоо болон бусад сурвалж бичиг, ардын аман домог яриа зэрэгт тэмдэглэгдэн хадгалагдаж үлдсэн Арван гурвын овоо, Долоон болдог, Шилхэнцэг, Аураг, Ацаагийн хад, Цоож чулуу, Ар өвөр хүйтэн, Чингисийн зам, Гүүн зэл, Далту ам, Сайр хээр, Харилд нуур, Хөдөө бүрд, гүн бүрд, Сэнгүр горхи, Хэрлэн гол, Гуа дов, Бөөгийн хэвтэш, Цэнхэр ус, Ухаа хаяа, Тугийн хоёр цохио, Тангарагийн улаан чулуу, Улаан булш, Булшит дэрс, Хар тал, Хөх нуур, Хүннүгийн дарлага, Таван зэрэг олон арван газар усны нэр түүх, домог болон өнөөг хүртэл уламжлагдан иржээ.

Мөн байгаль, түүх соёлын дурсгалт газар олон байдгаас Замагт нуурын 165 га, Чингисийн гүүн зэл буюу сүжийн талын 1263 га, Долоод уулын 1393 га, Ханан уулын 617 га, Хэрлэнтооно уулын 10962 га, Хөлийн нуурын 378га, Дэлгэрхаан уулын 1089 га, Их хайлантайн амны 891га нийт 16758га, Хэрлэн голын сав дагуух 47.991.6 га талбай нь аймаг орон нутгийн хамгаалалтанд байдаг.




Улсын хамгаалалтанд байгаа түүх соёлын дурсгал болох Аураг ордны туурийн 1230 га талбай, Их хайлант, Шар хад, Ханангийн энгэрт орших олон үеийн булш, чулуун зэвсгийн үеийн бууц, аймгийн хамгаалалтанд Гүн бүрд, Тооно ууланд орших хүн чулуун хөшөө, булш, хиргисүүр бүхий цогцолбор дурсгал, Долоод, Бурхан толгойн булш, хиргисүүрүүд, Хөшөөнө-Ухаад орших хүн чулуу, тахилгын чулуун хавтангууд, Хэрлэнбаян-Улаан уулын Хүйтэн хошуу, Бухын хошуу, Хэрээ хошууны булш, хиргисүүрүүд зэрэг дурсгалууд хамгаалагдаж байна.

Хүснэгт-83. Байгалийн үзэсгэлэнт газар.

Д/д	Нэр	Байршил	
1	Аварга тосон нуур	Сумын төвөөс баруун хойш 3 км	


2	"Аураг" рашаан	сумын төвөөс баруун урагш ,8км-т	
3	Хэрээ хад	сумын төвөөс хойш 21 км	
4	Хэрлэн тооно уулын овоо	сумын төвөөс урагш 18 км	
5	Тугийн хяр	сумын төвөөс урагш 18 км	
6	Алтан уул	Хэрлэнтооно уулын урд	
7	Гүн бүрд нуур	сумын төвөөс зүүн урагш 31 км	
8	Замагт нуур	Сумын төвөөс баруун урагш 20 км	
9	Хөдөө бүрд нуур	Сумын төвөөс баруун урагш 25 км	
10	Гоё зүрх (Баян зүрх) уул	Сумын төвөөс баруун хойш 42 км	
11	Их хайлантын ам	Сумын төвөөс хойш 17 км	
12	Хөх ханан	Дэлгэрхаан уулын зүүн урд	
13	Уугийн харанхуй	Сумын төвөөс баруун хойш 45 км	
14	Агуйт	Сумын төвөөс баруун хойш 30 км	
15	Тавдайн ханан	Сумын төвөөс баруун хойш 32 км	

Хүснэгт-84. Түүхийн дурсгалт газар.

Д/д	Нэр	Байршил	
1	МНТ-нд зориулсан гэрэлт хөшөө	сумын төвөөс баруун урагш ,8км-т	
2	Аваргын балгас	сумын төвөөс баруун урагш ,8км-т	
3	Хэрлэн тооно уулын хиргисүүр	Хэрлэнтооно уулын урд	
4	Арван гурван овоо /Сүүлд босгосон бөөгийн/	Аварга баг Дэлгэрхаан уулын овоо	
5	"Хэрлэний хөдөө арал" музей	сумын төвөөс баруун урагш ,8км-т	
6	Шилхэнцэг/Оорцог/	Сумын төвөөс урагш 17 км	
7	Буга уул /бичигт хад/	Хэрлэнтооно уулын урд Буга ууланд	
8	Ханангийн дурсгал /булш, түвд бичээс/	Долоод багийн төвийн хойно	
9	Сүжийн талын хүн чулуу	Сумын төвөөс баруун урагш 20 км	
10	Дээд хөшөө	Сумын төвөөс баруун урагш 25 км	
11	Дунд хөшөө	Сумын төвөөс баруун урагш 25 км	
12	Доод хөшөө	Сумын төвөөс баруун урагш 25 км	

13	Гурван дов	Сумын төвөөс баруун урагш 25 км	
14	Булштын хөвөө /Улаан булш/	Сумын төвөөс баруун урагш 25 км	
15	Хэрлэний Ханзатын дурсгал	Хэрлэнбаян-улаан тосгоны төвөөс баруун хойш 15 км	
16	Долоон болдог	Долоод багийн төвөөс баруун тийш 10 км	
17	Далтын ам	Долоод багийн төвөөс баруун хойш 12 км	
18	Буга хайрханы чулуун зэвсгийн дурсгал	Хэрлэнбаян-улаан тосгоны төвөөс баруун тийш 15 км	

Зураг-39. Түүх соёлын дурсгалт газар



4.3.4. Амьтны тархалт

Тус сумын нутаг нь дагуурын хээрийн тойрогт хамаарах боловч Хэнтийн тайгын тойрогтой хил залгаа учраас амьтны аймгийн зүйлийн бүрдэл харьцангуй баялаг юм. Тус сумын нутагт 2 зүйлийн хоёр нутагтан, 3 зүйлийн мөлхөгч, 109 зүйлийн шувуу, 53 зүйлийн хөхтөн амьтан оршидог байна.


Монгол Улсын Улаан номонд мөн ховор амьтдын жагсаалтад орсон нийт 7 зүйл шувуу болох Цагаан тогоруу, Цэн тогоруу, Гангар хун, Хонин тоодог, Хар өрөвтас, Хээрийн галуу, Халбаган хошуут, ач холбогдол бүхий зэвэг, хар мөрний хадран, хөхтөн амьтнаас Аргаль хонь, Дагуур зараа мөн олон улсын үнэлгээгээр устаж байгаа Халиун буга, устаж болзошгүй Монгол тарвага, Цагаан зээр ховордож байгаа саарал чоно зэрэг ан амьтан тархан байршиж байна.

Монгол улсын Улаан номд орсон Аргаль хонь нь өндөр бүс нутгаар амьдардаг хамгийн том зэрлэг хонь юм. Өндөр нь 120 см, 140 кг хүртэл жинтэй байх ба биеийн урт 1.8 м хүрнэ. Эр нь маш том угалзалсан эвэртэй бөгөөд 190 см хүртэл урт байдаг аж. Эм нь бас эвэртэй ч жижигхэн байна. Аргаль хонь нь Хэрлэн тооно уул, Баян ханы нуруу, Нурамт зэрэг уулсаар амьдардаг байна.



Халиун буга Монгол орны Хангай, Хэнтий, Хөвсгөл, Их Хянганы ой бүхий нутагт тархан амьдардаг. Туурайтны овогт багтах буга 85862.37га газар ойролцоогоо тархсан байна. Бугын тоо толгой 1980 онд Монгол орны хэмжээнд 140000 байсан бол өдгөө 8000 болж буурчээ. Халиун буга нь сумын Хэрлэн тооно уул, Баян ханы нуруу, Дэлгэрхаан уул, Баян уул, Ихэр уул зэрэг газараар амьдардаг


Зураг-40. Амьтны тархалт.



4.3.5. Ховор ургамлын тархалт

Дэлгэрхаан сумын нутагт Байгалийн ургамлын тухай хуулийн ховор ургамлын жагсаалтанд орсон 21 зүйл, нэн ховор 4 зүйл ургамал ургадаг байна. Эдгээр ургамлууд нь Алтан гагнуур, Ганга, Гишүүн, Зээргэн, Нохойн хошуу, Сонгино, Сөд, Эмийн багваахай, Эгэл хотой, Чоны элэг, Тэхийн шээг, Тарваган шийр, Тайжийн жинс, Таван салаа зэрэг ховор болон эмийн ач холбогдолтой ургамлууд ургадаг байна.

Зураг-41. Ховор ургамал, жимс, жимсгэний тархалт.



4.4. Сумын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ

ГХГЗЗГ-ын даргын тушаалын 2015 оны 9-р сарын 9-ний өдрийн А/200 тоот Газрын тохиромжтой байдлын үнэлгээний аргагүй, шалгуур үзүүлэлтүүд батлах тухай тушаалд зааснаар Дэлгэрхаан суманд бэлчээр, тариалан, хот суурин, ой, зам, шугам сүлжээ болон аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээг дараахь шалгуур аргачлалын дагуу хийсэн.

4.4.1. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ.


Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Тариалангийн газрын тохиромжтой байдлын иж бүрэн үнэлгээ”-г боловсруулна.

Тариаланд тохиромжтой газрын иж бүрэн үнэлгээ өгөхдөө хүрээлэн буй орчныг нэгдсэн систем гэж үзэж, байгаль болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлүүдийг хослуульж 5 шатлалтай ангиллаар үнэлгээний хүчин зүйлсийн үзүүлэлт бүрт тохируулан тогтоосон онооны (баллын) аргаар үнэлгээг боловсруулна. Үүнд:

1. Геофизик хүчин зүйлийн үнэлгээ
 - 1.1. Газрын гадаргын үнэлгээ;
 - 1.2. Гидрологийн үнэлгээ;
 - 1.3. Инженер-геологийн үнэлгээ;
 - 1.4. Хөрсний үнэлгээ;
2. Уур амьсгалын үнэлгээ
 - 2.1. Агаарын температур;
 - 2.2. Хур тунадас;
 - 2.3. Дулаан хангамжийн нөхцөл;
 - 2.4. Чийг хангамжийн нөхцөл;
3. Газар ашиглалтын суурь нөхцлийн үнэлгээ
 - 3.1. Ой бүхий талбай;
 - 3.2. Хот суурингийн газар;
 - 3.3. Зам, шугам сүлжээний газар;
 - 3.4. Тариалангийн талбай;
 - 3.5. Уул уурхайн талбай;
 - 3.6. Түүх соёлын дурсгалт газар;
 - 3.7. Археологийн үнэт олдвор;
 - 3.8. Гол, мөрөн;
 - 3.9. Булаг, худаг уст цэг;
 - 3.10. Манхан элс;

Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхэд График-25-д тусгагдсан нийт 3 үндсэн, 29 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэсэн.

График-25. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд



Хүснэгт-85. Тариаланд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.


Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	60927.84	15.9
Нэн тохиромжгүй	3156.25	0.8
Тохиромжгүй	73040.07	19
Хязгаарлагдмал тохиромжтой	125414.37	32.6
Тохиромжтой	121798.22	31.7

График-26. Тариалангийн газрын тохиромжтой байдлын эзлэх хувь.



Дэлгэрхаан сумын хувьд газар тариаланд тохиромжтой 121.8 мян.га орчим га газар байна. Хэрлэнэ тооно багийн Тэргэнэ оломын хөндий, Аварга багийн Хар тал буюу Баяны хар тал, Долоод багийн Сүүжийн тал, Хэрлэнбаян-Улаан багийн Шар нохойтын хөндий орчимын газар нь тариалангийн газарт тохиромжтой байна.

Зураг-42. Тариалангийн тохиромжтой байдлын үнэлгээний зураг



4.4.2. Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ.


Байгалийн нөөц рекреацийн нутаг дэвсгэр ашиглалтын урьдчилсан нөхцлүүдийн нэг гол хүчин зүйл, байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн төдийгүй түүний иж бүрдлийг бүхэлд нь хамардаг онцлогтой юм.

Дэлгэрхаан сумын Ландшафт-рекреацийн чадавхийн үнэлгээнд дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзэж шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Үүнд:

1. Ландшафтын үнэлгээ
 - 1.1. Газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээ
 - 1.2. Уур амьсгалын аялал-рекреацийн үнэлгээ
 - 1.3. Гадаргын ус- рашааны аялал-рекреацийн үнэлгээ
 - 1.4. Био нөөцийн аялал-рекреацийн үнэлгээ
 - 1.5. Ландшафтын гоо зүйн үнэлгээ
2. Байгаль, түүх, соёлын дурсгалт газрын үнэлгээ
 - 2.1. Байгаль-соёлын дурсгалт газар
 - 2.2. Түүх- соёлын дурсгалт газар
3. Дэд бүтцийн үнэлгээ
 - 3.1. Гатлага, зам (даваа, ус, элс, намаг, шавар, сөөгөн ширгэнэ)
 - 3.2. Хот болон байнгын оршин суух газарт ойрхон эсэх
 - 3.3. Тохижилтын түвшин
4. Газар ашиглалтын суурь нөхцөлийн үнэлгээ
 - 4.1.Тариалангийн талбай
 - 4.2.Одоо байгаа хот суурин газар
 - 4.3.Уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай
 - 4.4.Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн онгон болон онцгой бүс

Тухайн орон нутаг, бүс нутгийн ландшафт, байгаль, түүх, соёлын дурсгалт, дэд бүтэц, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Байгалийн аялал- рекреацийг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээ”-г боловсруулна. Байгалийн аялал- рекреацийг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээг 3 шатлалтай ангиллаар нийт 4 үндсэн, 27 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.

График-27. Ландшафтын үнэлгээний схем.




Хүснэгт-86. Аялал жуулчлалын газарт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.


Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	50486.8	13.1
Тохиромжгүй	6935.7	1.8
Хязгаарлагдмал тохиромжтой	29033.0	7.6
Тохиромжтой	297881.9	77.5

Тус сумын нутагт аялал жуулчлал хөгжүүлэх боломж нөхцөл байгаа бөгөөд нийт нутгийн 77.5% нь тохиромжтой байна.

График-28. Аялал жуулчлалын газарт тохиромжтой газрын эзлэх хувь.



Зураг-43. Аялал рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг



4.4.3. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ.


Зорилго нь Монгол оронд хот, суурин газар байгуулахад тохиромжтой болон тохиромжгүй бүс нутгийг үнэлэх ажлыг нэгдсэн зааварчилгаагаар хангахад оршино.

Шинээр байгуулах хот суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийхэд шаардагдах хүчин зүйл, тэдгээрийн шалгуур үзүүлэлтийн талаар Монгол улсын Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны 2010 онд боловсруулсан "Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар" (УББ 30-201-09)-т бүрэн тусгагдсан учраас энэхүү батлагдсан баримт бичигт үндэслэн тохиромжтой байдлын үнэлгээг хийнэ. Ингэхдээ дээрх аргачилсан зааварт тусгагдсан 4 үндсэн, 43 дэд үзүүлэлтээс 3 үндсэн 19 дэд үзүүлэлтийг хэвээр үлдээж, 1 үндсэн, 16 дэд үзүүлэлтийг шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Үүнд:

Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, инженер геологийн нөхцөл, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Шинээр байгуулах хот суурины дэвсгэр газрын тохиромжтой байдлын иж бүрэн үнэлгээ”-г боловсруулна.

Шинээр байгуулах хот суурины дэвсгэр газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхэд График-29-д тусгагдсан нийт 3 үндсэн, 35 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.


График-29. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний



Хүснэгт-87. Шинээр байгуулах хот, суурин газарт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	59659.0	15.5
Тохиромжгүй	21347.0	5.6
Хязгаарлагдмал тохиромжтой	112744.4	29.3
Тохиромжтой	190585.8	49.6

Зураг-44. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг



4.4.4. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ.

Тухайн орон нутаг, бүс нутгийн бэлчээрийн ургамлын анги, бүлэг төрөл, идэмж, байгалийн бүс бүслүүр, гадаргын нөхцөл, усан хангамж, бэлчээрийн хэв шинж зэрэг үзүүлэлтэд үндэслэн үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Хадлан, бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ”-г боловсруулна. Хадлан, бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг бэлчээрийн ургамлын 250 анги, бүлэг төрлөөр 7 үндсэн үзүүлэлтэд үндэслэн гүйцэтгэнэ. /График-30/

График-30. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний схем.




Хүснэгт-88. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /Өвөл-Хавар/.

Д/д	Үнэлгээ	Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
1	Бусад газар ашиглалт	50443.8	50432.0	50423.1	50501.9	50432.0
2	Тохиромжгүй	19051.9	19987.3	49483.7	5046.5	19987.3
3	Дунд зэрэг тохиромжтой	20563.6	24915.8	159502.2	51271.5	24915.8
4	Тохиромжтой	52117.7	134551.9	118752.2	195447.5	134551.9
5	Нэн тохиромжтой	242160.2	154450.4	6175.7	82069.8	154450.4


Хүснэгт-89. Таван хошуу малд тохиромжтой газрын хэмжээ, хувь /Өвөл-хавар/.

Үнэлгээ	Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
Бусад газар ашиглалт	13.1	13.1	13.1	13.1	13.1
Тохиромжгүй	5.0	5.2	12.9	1.3	5.2
Дунд зэрэг тохиромжтой	5.4	6.5	41.5	13.3	6.5
Тохиромжтой	13.6	35.0	30.9	50.9	35.0
Нэн тохиромжтой	63.0	40.2	1.6	21.4	40.2


График-31. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /Өвөл-хавар/.




Зураг-45. Өвөл-Хаврын улиралд адуунд тохирох бэлчээрийн зураг.




Зураг-46. Өвөл-Хаврын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг.




Зураг-47. Өвөл-Хаврын улиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг.



Зураг-48. Өвөл-Хаврын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг.



Зураг-49. Өвөл-Хаврын улиралд хонинд тохирох бэлчээрийн зураг.




Хүснэгт-90. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /Зун-Намар/.

Д/д	Үнэлгээ	Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
1	Бусад газар ашиглалт	50437.4	50534.9	50458.0	50451.5	50534.9
2	Тохиромжгүй	579.5	27876.1	31663.0	9214.3	27876.1
3	Дунд зэрэг тохиромжтой	29181.0	10317.2	94178.5	45675.5	10317.2
4	Тохиромжтой	71694.7	88702.9	188122.7	198467.1	88702.9
5	Нэн тохиромжтой	232444.8	206906.2	19915.1	80528.4	206906.2


Хүснэгт-91. Таван хошуу малд тохиромжтой газрын хэмжээ, хувь /Зун-намар/.

Үнэлгээ	Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
Бусад газар ашиглалт	13.1	13.1	13.1	13.1	13.1
Тохиромжгүй	0.2	7.3	8.2	2.4	7.3
Дунд зэрэг тохиромжтой	7.6	2.7	24.5	11.9	2.7
Тохиромжтой	18.7	23.1	48.9	51.6	23.1
Нэн тохиромжтой	60.5	53.8	5.2	21.0	53.8


График-32. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /Зун-намар/.




Зураг-50. Зун-Намрын улиралд адуунд тохирох бэлчээрийн зураг.




Зураг-51. Зун-Намрын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг.




Зураг-52. Зун-Намрын улиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг.



Зураг-53. Зун-Намрын улиралд хонинд тохирох бэлчээрийн зураг.




Зураг-54. Зун-Намрын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг.



4.4.5. Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ.

Тухайн орон нутаг, бүс нутгийн ой- ургамалжлын муж, хошуу, өндрийн бүслүүр ангилалд үндэслэн гадаргын нөхцөл, хөрсний шинж чанарыг илтгэх үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээ”-г боловсруулна. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээг байгалийн 3 өөр муж, 9 хошуу, өндрийн бүслүүрээр ялгаатай 22 ойн хэв шинжид үндэслэн нийт 3 үндсэн, 11 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.


График-33. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээний.



Хүснэгт-92. Ой санд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.

Д/д	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	50353.6	56.9
2	Тохиромжгүй	121500.2	137.3
3	Хязгаарлагдмал тохиромжтой	210598.8	238.0
4	Тохиромжтой	1885.6	2.1
Нийт талбай		88483.3	100.0

Зураг-55. Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.




4.4.6. Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ.

Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, инженер геологийн нөхцөл, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын үнэлгээ”-г боловсруулна.

Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын үнэлгээг хийхэд зураг 1-д тусгагдсан нийт 3 үндсэн, 6 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.

График-34. Шугаман байгууламжийн тохиромжтой байдлын үнэлгээ.




Хүснэгт-93. Авто замд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.

Д/д	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Нэн хүндрэлтэй	74511.7	19.4
2	Хүндрэлтэй	87770.4	22.8
3	Хэвийн	222055.3	57.8


Хүснэгт-94. Шугам сүлжээд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.

Д/д	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Нэн хүндрэлтэй	118202.6	30.8
2	Хүндрэлтэй	133463.6	34.7
3	Хэвийн	132672.4	34.5


Зураг-56. Авто зам болон төмөр замын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.




Зураг-57. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.



Зураг-58. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.



Зураг-59. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.



ТАВ. СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**5.1. Иргэдийн оролцоотой ашиглалтын олон хэлбэр бүхий газрын хэрэгцээт байдлыг тогтоох**

Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд нутгийн иргэдийн оролцоо хамгаас чухал. Төлөвлөгөөнд орон нутгийн иргэд оролцож, тэдний санал тусгагдаж байж хэрэгжих боломж хангагдана. Иймээс төлөвлөгөөнд иргэдийг оролцуулах нөхцлийг бүрдүүлж ажиллалаа.

Иргэдийн санал бодлыг нутаг дэвсгэрийн төлөвлөлтөнд тусгуулах, ашиглалтын олон хэлбэр бүхий газрын хэрэгцээг тодорхойлох нь сумын тогтвортой хөгжилд чухал ач холбогдолтой. Иргэд, аж ахуйн нэгж нь газрыг хууль эрх зүйн дагуу албан болон албан бус хэлбэрээр ашиглан эзэмшдэг. Газар ашиглалтын олон хэлбэр үүсч байгаа цаг үед иргэн, аж ахуйн нэгжид газрыг зориулалтаар нь зүй ёсны эрхээр баталгаажуулах нь сумын хөгжил болон иргэдийн амьдрал ахуйд ойрхон шийдвэр болно. Иймээс төлөвлөлтөнд иргэдийн оролцоог хангах үүднээс дараахь аргуудыг хэрэглэнэ. Үүнд: нүүр тулсан уулзалт, уулзалт ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, асуулгын судалгаа, зорилтот бүлгийн саналаар хийгдсэн зураглал, хэмжилт болон сумын онцлогыг харуулах дүн шинжилгээг хийж төлөвлөлтөд тусгалаа.

Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг боловсруулахад иргэдийн оролцоог хангах үүднээс малчин, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 25%, сумын засаг даргын тамгын газрын ажилтнуудын 70%-ийг судалгаанд хамруулж санал авч хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөлтөнд дараах байдлаар санал, хэлэлцүүлгийн зохион байгууллаа. Үүнд:

- Дэлгэрхаан сумын иргэд, хуулийн этгээд, малчин өрхөөс түүвэрлэх байдлаар санал авах. Сумын төвийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа иргэдээс эхлэн хөдөөгийн малчдыг хамруулж саналын хуудасаар санал авсан.
- Сумын Засаг даргын тамгын газрын удирдлага, мэргэжилтнүүдийн саналыг авах, хэлэлцүүлэг хийх. Сумын удирдлага, багийн засаг дарга нар, МЭҮТ-ын мэргэжилтнүүд, нийгмийн ажилтнууд зэрэг ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэнгүүдтэй уулзаж хэлэлцүүлэг зохион байгуулж тэдгээрийн бодлого болон мэргэжлийн чиглэлээр сум орондоо бариж ажиллаж байгаа хөтөлбөр, чиглэлүүдийн саналыг авч төлөвлөгөөнд тусгасан.
- Багийн Иргэдийн нийтийн хурлаар багийн бүх иргэдийг хэлэлцүүлэх, санал авах. Дөрвөн багийн Иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулж тэдний саналыг авч төлөвлөгөөний загвар төслийг танилцуулж холбогдох санал хэлэлцүүлгийг хийж

төлөвлөгөөндөө тусган энэхүү багийн Иргэдийн нийтийн хурлаас гарсан тогтоол, шийдвэрүүдийг /тэмдэглэл/ зурагт буулган боловсруулалт хийж сумын Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлаар оруулж хэлэлцүүлэн санал бодлыг авч төлөвлөгөөг боловсрууллаа.

Хүснэгт-95. Иргэдээс авсан саналын судалгаа /4 иргэний жишээн дээр/.

№	Асуулт:	1	2	3	4
1	Санал өгөгчийн овог нэр	О.Ууганбаяр	Д.Цэцэгсайхан	Ц.Бат-Эрдэнэ	Б.Ваанчиг
2	Төрөл	Иргэн	Иргэн	Иргэн	Иргэн
3	Утас, хаяг	Аварга баг, хийд 6-4	Аварга баг	Хэрлэнбаян-Улаан баг	Хэрлэнбаян-Улаан баг
		96568771	98829362		98187910
4	Санал	Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах нэгдсэн төлөвлөлт гаргах	Аварга Бэлчээр усжуулах	1. Худаг засварлах 2. Отрын малчдыг хугацаанд нь нүүлгэх	1. Дэлгэрхаан сумыг отрын нутгаас чөлөөлөх 2. Хадлангийн талбай хаших
5	Төслийн зориулалт	Газар тариалан /Эрүүл, аюулгүй, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах/	Бэлчээр усжуулах	Бэлчээр усжуулах	Хадлангийн талбай хаших
6	Туршлага	Туршлага байхгүй	Туршлага байхгүй	Туршлага байхгүй	
7	Нөөц боломж /өөрийн болон бусад/	Тариалангийн талбай хашаажуулж, тариалах боломжтой	Оршин суугч малчид	Төрөөс санхүүжүүлэх	
8	Бусад газар ашиглалттай уялдаатай эсэх				Өвс сайтай бэлчээр, усны гачигдалтай
Санал болгож буй төслийн мэдээлэл:					
9	Харъяалагдах засаг захиргаа, багийн нэр	Аварга баг	Аварга баг	Хэрлэнбаян-Улаан баг	Хэрлэнбаян-Улаан баг

10	<i>Байршил /координат/ газрын нэр</i>	Аваргын гол, Аваргын боом	Баяны энгэрээс доош хар талын баруун талаар	Цохионы арын худгийг засварлах	Багийн нутаг дэвсгэрт
11	<i>Шаардагдах талбайн хэмжээ</i>	5 га			
12	<i>Хөрөнгө оруулалтын байдал</i>	СХС, ЖДБЭС, Зээл, өөрийн хөрөнгөөр	Улсын болон орон нутгийн	Улсын болон орон нутгийн	Хөрөнгийн туслалцаа шаардлагатай
13	<i>Орон нутагт үзүүлэх нөлөөлөл</i>	Ажлын байр нэмэгдэнэ	Эерэг		Мал, малчид бэлчээр нутагтай болно
14	<i>Хэрэгжих хугацааны төсөөлөл /жил, сар/</i>	5 – 10 жил			
15	<i>Орон нутгийн хөгжилтэй уялдсан эсэх</i>	Уялдсан			Уялдсан
16	<i>Байгаль орчин, түүнд үзүүлэх нөлөөлөл</i>	Сөрөг нөлөө байхгүй	Сөрөг нөлөө байхгүй		

Нийт иргэдийн дийлэнх хувь нь худаг уст цэг гаргах, мөн Хэрлэн баян-Улааныг отрын нөөцөөс гаргах, хадлангийн талбай хаших, тариалангийн газартай болох, өөр сумаас айл шилжүүлэн авахгүй байх, улирлын бэлчээрийг зааглаж чанд мөрдөх, зуны бэлчээр шинээр хаваржаа олгохгүй байх, бэлчээрийг гэрээгээр ашиглах, өрхийн аж ахуй эрхлэх чиглэлээр санал өгсөн байна.

5.2. Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө

Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөлтийг газрын болон байгалийн нөөц нөхцөлд тулгуурлан дараахь эрхзүйн баримт бичгүүдийг үндэслэн боловсруулсан. Үүнд:

- “Аймаг, Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргазүйн заавар” УБ, 2008 он
- Хэнтий аймгийн аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тайлан
- “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” УБ, 2011 он
- Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм
- Монгол улсын стандарт MNS 4652-28
- Монгол улсын стандарт MNS 4628-98 “Шатахуун түгээх станц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага” УБ, 1998 он
- “Харилцаа холбооны тухай хууль”, Засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоол
- "Авто замын тухай хууль"-ийн 12.2 зүйл
- “Ойн тухай хууль” 2012 оны 5-р сарын 17
- “Аялал жуулчлалын тухай хууль” 2000 оны 5-р сарын 5

Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд дараахь үндсэн шийдлүүдийг тусгасан. Үүнд:

- Сумын нутаг дэвсгэрийн одоо байгаа газар ашиглалтыг хэвээр хадгалан үлдээх; Энэ ерөнхий төлөвлөгөө боловсруулах болон хэрэгжүүлэх бүхий л үе шатанд энэ зарчмыг хэвээр хадгалж үргэлжлүүлэх нь зүйтэй.
- Сумын хэмжээнд усан сан, ойн сан, зам шугам сүлжээ зэрэг заавал хамгаалах шаардлагатай хамгаалалтын бүсүүдийг тогтоох;
- Бэлчээрийн улирлын хуваарийн хил заагийг тогтоон улирлын бэлчээрийн даацыг тооцох;
- Бэлчээр ашиглалтын хэсгийн хил түүнд багтах багтах малын багтаамжийг тооцох;
- Хөрс ургамлын төрлөөс нь хамааран хадлангийн газрыг тогтоох;
- Аялал жуулчлал, амрал зугаалгын бүс нутаг, явган болон морин аялал зохион байгуулах боломжтой маршрутыг гаргах;
- Сумын төв болон зохих шаардлагатай газруудыг аймаг болон хооронд нь холбосон авто зам, эрчим хүч, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийг төлөвлөж зурагжуулах;
- Байгаль экологи, биологийн олон янз байдлын тогтоц нөөцтэй газруудыг судлан тогтоож орон нутаг болон улсын тусгай хэрэгцээнд авах;

➤ Баталгаажуулах боломжтой Байгалийн нөөц эдэлбэрийн эрхүүдийг тогтоох;
Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулахад олон чиглэлийн заавар стандартуудыг ашигласан бөгөөд дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт-96. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулахад хэрэглэгдэх заавар, стандартууд.


Аргачлал, стандарт	Тайлбар	
Тохиромжтой байдлын үнэлгээ хийх арга	ГЗГЗЗГ-ын даргын 2015 оны 09-р сарын 09-ны өдрийн А/200 тоот тушаал	
Бэлчээрийн ургац тодорхойлох арга зүй	БОНХ-ын сайдын 2011 оны А114 дүгээр тушаал	
Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэцийг тодорхойлох	Л.Г.Раменскийн квадрат торыг ашиглах арга. /Избранные работы. Проблемы и методы изучения растительного покрова/ Изд. Наука. 1971 г.	
Бэлчээрийн багтаамж	ХХАА-н сайдын 2010 оны 148-р тушаал	
Бэлчээрийн хөрсний элэгдэл эвдрэл, зэрэглэл тогтоох	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль тогтоомжийн хялбаршуулсан лавлах Улаанбаатар 2012 “Бэлчээрийн хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага“ MNS 5546:2005	
Бэлчээрийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, талхлагдал, зэрэглэл тогтоох		
Хөрсний бохирдолт	Хөрсний бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008	
Хар тугалга, Кадмы, Хром, Зэс Никель, Кобальт, Цайр	Атом шингэлтийн спектрометрийн арга MNS ISO 11047:2001	
Ургамлын арви үнэлэх	О.Друдегийн 1913 В ведение в геоботанику Изд. Ленинградского университета. 1964 г.	
Усжуулагдсан бэлчээрийн талбайг тодорхойлох	Усны аж ахуйн яам, УХСЗТИ “Усжуулагдсан бэлчээрийн талбайг тодорхойлох аргачлал”. Улаанбаатар 1971 он	
Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх аймаг, сумын жагсаалт	“Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2002 оны 160-р тогтоолын 2-р хавсралт	
Малын төрлийг хонин толгойд шилжүүлэх	1997 оны Газрын төлбөрийн хуулийн 6-2, Үндэсний Статистикийн хорооны хөдөө аж ахуйн салбарын тайлан, 2013	
Нийгэм-эдийн засгийн судалгаа	Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн боловсруулсан “Социологийн судалгааны арга зүй, аргачлал” УБ 2008	
Шатсан ой, хортон мэрэгчид идэгдсэн ой	Ой зохион байгуулалтын материал.	
ГЗБТөлөвлөгөөний зураг боловсруулах	MNS 6317: 2012, MNS 6316:2012 стандарт	
Усны чанарыг тодорхойлох стандартууд	Шинжилгээний үзүүлэлт	Хэрэглэж буй арга

Төлөвлөлтийг газар ашиглалтын бүсүүдээр дараахь графикын дагуу хийж гүйцэтгэсэн.

График-35. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний бүсүүд.



Зураг-60. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний зураг.




5.2.1. Хамгаалалтын бүсийн төлөвлөгөө

Гадаргын ус, худаг, шатахуун түгээх станц, өндөр хүчдлийн шугам, авто замуудад дараахь төрлийн хамгаалалтын бүсүүдийг төлөвлөсөн.

Хүснэгт-97. Сумын хамгаалалтын бүсүүдийн төлөвлөгөө.

№	Барилга байгууламжийн төрөл	Хамгаалалтын бүсийн төрөл	Эрхзүйн баримт бичиг	Хамгаалалтын бүсийн өргөн, м
1	Голууд	Хориглох бүс	Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм	25
2	Голууд	Хязгаарлах бүс	Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм	50
3	Нуурууд	Хориглох бүс	Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм	25
4	Нуурууд	Хязгаарлах бүс	Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм	50
5	Худаг	Хамгаалалтын бүс	Монгол улсын стандарт MNS 4652-28	50
6	Шатахуун түгээх станц	Хамгаалалтын бүс	Монгол улсын стандарт MNS 4628-98	50
7	Өндөр хүчдэлийн шугам	Хамгаалалтын бүс	"Харилцаа холбооны тухай хууль", Засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоол	10
8	Улсын чанартай авто зам	Зурвас газар	"Авто замын тухай хууль"-ийн 12.2 зүйл	100
9	Орон нутгийн чанартай авто зам	Зурвас газар	"Авто замын тухай хууль"-ийн 12.2 зүйл	60

Зураг-61. Хамгаалалтын бүсүүдийн төлөвлөгөөний зураг.



Хүснэгт-98. Сумын хамгаалалтын бүсүүдийн талбайн хэмжээ.

Хамгаалалтын бүс	Хамгаалалтын бүсийн өргөн	Талбай, га	Үндэслэл
Булгийн онцгой хамгаалалтын бүс	50 м	31.33	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
Булгийн энгийн хамгаалалтын бүс	200 м	446.69	
Нуурын онцгой хамгаалалтын бүс	100 м	75.72	
Нуурын энгийн хамгаалалтын бүс	200 м	92.98	
Худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс	50 м	64.72	
Худгийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүс	200 м	864.08	
Хамгаалалтын бүсийн ой	100 га хүртлэх хэмжээний ой	1715.91	Ойн тухай хууль
	Тусгай хамгаалалттай газрын ой	775.28	
Ашиглалтын бүсийн ой	Бусад ой	19003.50	
Холбооны шугамын хамгаалалтын зурвас	10 м	152.98	Харилцаа холбооны тухай хууль
Эрчим хүчний шугамын хамгаалалтын зурвас	10 м	139.74	Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм

Дэлгэрхаан сумын газар нутагт гадаргын усны хамгаалалтын бүсүүд, ойн хамгаалалтын бүс, зам шугам сүлжээний хамгаалалтын бүсүүдийг тогтоож зохих газрын хэмжээг тогтооход нийт 23362.93 га газар хамарч байна. Үүнийн 1.3%-ийг усны шугас сүлжээний газар хамгаалалтын бүс, 6.7%-ийг усны хамгаалалтын бүс, 92%-ийг ойн хамгаалалтын бүс тус тус эзэлж байна.

“Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм”-д зааснаар гадаргын усны нөөцийг бохирдох хомсдохоос хамгаалах зорилгоор хориглох болон хязгаарлах бүсүүд тогтоох бөгөөд дараахь зориулалтаар газар ашиглахыг хориглоно.

Хориглох бүсэд дараахь зориулалтаар газар ашиглахыг хориглоно. Үүнд:

- Гол нуур цөөрөм, булгийн усыг хомсдуулж, ширгээх болон чанарыг нь муутган өөрчлөх нөлөөлөлтэй үйлдвэр, барилга байгууламж /цэвэрлэх байгууламж, нефть бааз, цахилгаан станц/ барьж ашиглах (энэ заалтанд зөвхөн ус хангамжийн төвлөрсөн системийн барилга байгууламжийг үл хамааруулна).
- Химийн хорт бодис, төрөл бүрийн бордоо, цацраг идэвхт бодис болон түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй барилга байгууламж байрлуулах
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газрыг ашиглах
- Барилгын карьер гаргах
- Гахай шувууны байр, саалийн механикжсан ферм, мал угаах цэг байршуулах.

- Автомашины шатахуун түгээх газар байгуулах, машин техник угаах, засварлах, бохир усны нүх, бие засах газар барих.
- Байгаль хамгаалах зохих арга хэмжээг авахгүйгээр амралт сувилалын газар байгуулах.

Хязгаарлах бүсэд дараахь зориулалтаар газар ашиглахыг хориглоно. Үүнд:

- Гол нуур цөөрөм, булгийн усыг хомсдуулж, ширгээх болон чанарыг нь муутган өөрчлөх нөлөөлөлтэй үйлдвэр, барилга байгууламж /цэвэрлэх байгууламж, нефть бааз, цахилгаан станц/ барьж ашиглах (энэ заалтанд зөвхөн ус хангамжийн төвлөрсөн системийн барилга байгууламжийг үл хамааруулна).
- Химийн хорт бодис, төрөл бүрийн бордоо, цацраг идэвхт бодис болон түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй барилга байгууламж байрлуулах.
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газрыг ашиглах.
- Автомашины шатахуун түгээх газар байгуулах.

Шатахуун түгээх станцын хамгаалалтын бүсэд дараахь зориулалтаар газар ашиглахыг хориглоно. Үүнд:

- Орон сууц, нийтийн үйлчилгээний газар
- Хүнсний үйлдвэрлэлийн объект
- Гэр хороолол
- Албан газрын барилга байгууламж.

Дэлгэрхаан сумын нутаг дахь Аварга тосон нуур нь гадаад болон дотоодын амрагч нарын гол очиж сувилиулдаг газар бөгөөд энэ нуурын урд дэнж дээр олон амралт сувилалын газар байдаг. Сумын иргэд, аж ахуй нэгж нь тус газар үйл үйл ажиллгаагаа явуулж амьдрал ахуйгаа залгаж байдаг тул нуурын орчмын унаган төрхийг нь хадгалж нуурын усны түвшинг хамгаалах үүдээс хамгаалалтын бүсийн гормыг чанд мөрдөж 6 сарын 15-наас 8 сарын 20 хооронд нуураас гадагш 5 км зайд мал оруулахгүй байх нь зүйтэй юм.

-

5.2.2. Бэлчээрийн газрын төлөвлөгөө

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тухайн нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны нутгуудад хуваарилан Багийн ИНХ-аар хэлэлцүүлж цаашид ИТХ батлуулж ажиллах боломжтой тул бэлчээрийн газрыг хуваарилан төлөвлөгөөнд тусгалаа.

Бэлчээрийн газарт нөлөөлөх хүчин зүйлүүдэд газарзүйн байрлал, газрын гадаргын хэв шинж, байгаль цаг уурын онцлогтой уялдуулан бэлчээрийн улирлын ашиглалтын байршлыг тогтоож зураглалаа. Бэлчээрийн улирлын ашиглалтыг дараах төрлүүдэд хуваана. Үүнд:

1. Өвлийн бэлчээр–өвлийн улирал нь агаарын температур хамгийн хүйтэн, бэлчээрийн ургамлын шим муудаж, хагдарч унасан, цасанд дарагдсан, ил задгай усгүй болсон хамгийн ширүүн улирал юм. Иймд өвлийн бэлчээрээр салхи багатай нөмөр нөөлөгтэй, нимгэн цас унадаг, үетэн ургамал зонхилсон, уул толгодын өвөр энгэр ээвэр болон дэрс буттай хотгор газрыг сонгоно.
2. Хаврын бэлчээр–Агаарын температур нэмэх градус тавих шилжиж дулаарах боловч огцом хүйтрэх, хүчтэй шуурга тавих зэрэг эрс тэс нөхцөл байнга тохиолдож мал төллөж эхэлддэг. Иймд малчид гарсан төлийг бойжуулахад онцгой анхаардаг учраас хаврын улирлын бэлчээр нь малыг салхинаас нөмөрлөсөн, цас түрүүлж хайлдаг энгэр ээвэр, чийг сайтай, зөөлөн хөрстэй бууцнаасаа холгүй газрыг сонгоно.
3. Өвөл хаврын бэлчээр–Өвөл хаврын улиралд дараалан нутаглах боломжтой өвөл хаврын бэлчээрийн төрх, нөхцөлийг хангасан газрыг сонгоно.
4. Зун намрын бэлчээр–Зун намрын улиралд дараалан нутаглах боломжтой зун намрын бэлчээрийн бэлчээрийн төрх, нөхцөлийг хангасан газрыг сонгоно.
5. 4 улирал буюу эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бэлчээр–Сүүлийн жилүүдэд төв суурин газарлуу шилжих хөдөлгөөн нэмэгдэж бэлчээрийн сэлгээ хийх нөөц хомсдсон, нөгөөтэйгүүр малчид маань нэг газраа төвхинөж цөөн тооны ашиг шим өндөртэй малтай өрх нэмэгдсэн зэрэг шалтгаанаас болж нэг доороо жил тойрон нутаглах болсон. Иймд 4 улиралд ашиглах боломжтой нөхцөл бүрдсэн газрын сонгоно.
6. Бусад–алслагдсан болон худаг уст цэг байхгүйн улмаас ашиглагдахгүй байгаа бэлчээр .

Дэлгэрхаан сумын хувьд бэлчээрийн газар нь 6 хэв шинжийн улирлын хэсгээр бэлчээрийг ашиглаж байгаа бөгөөд сумын нийт бэлчээрийн 51.3% буюу 188562.5 га

бэлчээрийг өвлийн улиралд, 19.6% буюу 72080.1 га бэлчээрийг хаврын улиралд, 1.1% буюу 3985 га бэлчээрийг өвөл-хаврын улиралд, 3.2% буюу 11756.9 га бэлчээрийг зуны улиралд, 4.2% буюу 15455.6 га бэлчээрийг намрын улиралд 20.6 хувь буюу 76638.3 га талбайг зус, намрын улирал тус тус ашигладагыг хээрийн хэмжилт судалгаа, тохиромжтой байдлын үнэлгээ, одоогийн ашиглалтын байдал, санал асуулга, хэлэлцүүлэг зэрэг олон хүчин зүйлийн хамаарлаас судлан тогтоолоо. Жилийн дөрвөн улиралд байнга нэг дороо нутагладаг хөдөөгийн малчин өрх байхгүй байна.

Хүснэгт-99. Сумын улирлын бэлчээр ашиглалт, багаар.


Д/д	Бэлчээрийн төрөл	Хэрлэнбаян-Улаан	Долоод	Аварга	Хэрлэн тооно	Нийт
1	Намаржаа	11756.7		3698.9		15455.6
2	Зуслан			10113.2	1643.7	11756.9
3	Зуслан, намаржаа	23300.5	23090.6	12788.6	16458.6	75638.3
4	Өвөлжөө	77638.2	41350.5	40173.6	29400.2	188562.5
5	Хаваржаа	8757.6	24713.2	19911.3	18698.0	72080.1
6	Өвөлжөө, хаваржаа				3985.0	3985.0
	Нийт	121452.8	89154.2	86685.7	70185.5	367478.3

Дэлгэрхаан сумд тодорхойлсон бэлчээрийн улирлын ашиглалтуудын багтаамжыг сумын хэмжээгээр авч үзэхэд зун, намрын бэлчээрийн даац багтаамж харьцангуй сайн, өвлийн бэлчээрийн даац багтаамж бага байна. Хаврын улиралд ашиглагдаж байгаа бэлчээр нь бага хэмжээний газар нутагт маш олон айл хаварждаг учир бэлчээрийн даац 10 дахин хэтэрсэн маш их ашиглалттай байна. Иймд хавар болон өвлийн улирлын бэлчээрийг хугацаандаа ашиглах, мөн хаваржаа, өвөлжөөний нутагт малчин өрхүүдийг бага нэмэх хэрэгтэй. Зуслангийн бэлчээр нь богино хугацаанд ашиглагддаг тул харьцангуй ургац сайтай байна.

График-36. Улирлын бэлчээрийн эзлэх хувь.



Зураг-62. Улирлын бэлчээр ашиглалтын зураг.




5.2.3. Бэлчээр усжуулалт

Гадаргын усны судалгааг гаргасны үндсэн дээр Дэлгэрхаан сумын хэмжээнд усжуулагдсан нутаг 312426.32 га буюу 81.4 хувь нь бөгөөд харин усжуулах шаардлагатай нутаг бэлчээр 71493.14 га буюу 18.6 хувь байна. Усжуулах шаардлагатай бэлчээрийн 34.1 буюу 24388.7 га бэлчээр нь Аварга баг, 29.3 хувь буюу 20948.9 га бэлчээр нь Хэрлэн тооно баг, 19.2 хувь буюу 13714.4 га бэлчээр Долоод баг, 17.4 хувь буюу 12441.1 га бэлчээр Хэрлэнбаян-Улаан багт тус тус байна.


Хүснэгт-100. Бэлчээр усжуулалтын судалгаа.

Бэлчээр	Баг	Талбай, га
Усжуулагдсан бэлчээр	Хэрлэн Баян-Улаан	120496.75
	Долоод	75813.09
	Аварга	66872.13
	Хэрлэн тооно	49244.36
Усжуулах шаардлагатай бэлчээр	Хэрлэн Баян-Улаан	12441.07
	Долоод баг	13714.53
	Аварга баг	24388.67
	Хэрлэн тооно	20948.88

График-37. Бэлчээр усжуулалт хувь.



Зураг-63. Усжуулах шаардлагатай бэлчээр.



5.2.4. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө

Бэлчээрийн газар ашиглалт нь сумын үндсэн газар ашиглалт байгаа бөгөөд цаашид бэлчээрийг өнө удаан хугацаанд тогтвортой ашиглахын тулд улирлын сэлгээг сайн хийх, бэлчээрийн даац багтаамжид тааруулж малаа өсгөх, хамгаалах, тордох, эзэнтэй болгох, нөхөн сэргээдэг байх шаардлагатай. Иймд бид энэхүү нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд бэлчээр ашиглалтын хэсэг гэсэн бэлчээр ашиглалтын хэлбэрийг тогтоож төлөвлөгөөнд тусгалаа. Энэхүү бэлчээр ашиглалтын хэсгийг малчдын саналын үндсэн дээр тогтоосон ба Багийн Иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлж тогтоосон болно. Дэлгэрхаан сумын хэмжээнд бэлчээр ашиглалтын 86 хэсгийг тогтоож энэхүү төлөвлөгөөнд тусгасан ба хэсэг бүрт багтах малчдын байршлын тоог хүснэгт 101 харуулав.


Хүснэгт-101. Бэлчээр ашиглалтын хэсгийн талбай.

Д/д	Бэлчээр ашиглалтын хэсгийн нэр	Талбай /га/	Малчдын байршлын тоо					
			Өвөлжөө	Хаваржа а	Өвөлжөө	Хаваржа а	Зуслан	Намаржа а
1	Аварга тосон	3698.93		1				
2	Билүүт-1	655.65						
3	Хар тал	9362.04	1	16				
4	Баяны хар тал	7636.23	3	112			1	
5	Хойд хар тал	2912.60	4	15				
6	Сумын төв	12788.61			2		1	
7	Бугат	9457.54	23				1	
8	Арцатын мухар, Бадрах уул	13752.46	28	2			1	
9	Агуйтын гол	8170.24	18					
10	Агуйтын эх	2460.02	4					
11	Уугийн гол, Их ёл	2907.84	4					
12	Дэлгэрхаан уул, Устын ам	12883.09	4					
13	Замтын баруун урд, Хэрлэн гол	605.83		3			1	
14	Аваргын бэлчир, Хэрлэнгийн тохой	1359.74		5				
15	Хэрлэн-4	1514.09		6				
16	Хэрлэн-2	789.01		2				
17	Хэрлэн-3	1570.64		7				
18	Хэрлэн-1	12016.94		15				
19	Тэмээн нуур	7542.01	1	10				
20	Зуслан, намаржаа	22405.46		16				2
21	Дэндгэр толгой	2166.01	1	2				
22	Хана	958.09	4					
23	Баян Цогт	1812.49	5					
24	Босгын ухаа, Нөөлөгт	3416.09	6					
25	Хар толгой	1749.01	5	1				

26	Дэлгэр хөндий голын адаг	3704.95	15				
27	Баян Мөнх толгой	1607.57	5			1	
28	Далгай толгой	3131.86	14				
29	Хар чулуут	2757.27	4				
30	Шаагийн гозгор	1450.14	8				
31	Орзон, Өлий худаг	4000.59	11				
32	Устын гол	1296.01	3				
33	Шуухарын хошуу	1059.63	1				
34	Дэлгэр хөндий	3998.45	14				
35	Наймаа, Барчин	2563.00	3				
36	Устын гол-2	2703.66	3				
37	Хөх хад	2975.64	9				
38	Зуслан, намаржаа	6056.44	3	1			
39	Эвийн ухаа, Дааган дэл	3984.99		6			
40	Эхэн шандны хонхор	3206.70		10			
41	Бугын суга	6670.70		10			
42	Зараа булан	1692.87		7			
43	Зуслан, намаржаа	1198.21		1			
44	Үрүү Чулуу	1177.27	4			1	
45	Тоонот	1348.13	5			1	
46	Дуулга	322.43	3				
47	Тахилт урд хөндий	359.67	1				
48	Хэрлэн тооно	2562.96	4	2			
49	Хавтгай толгой	473.86	3				
50	Сэрвэн	1728.48	4	1			
51	Тахилт	1509.20	5				
52	Уушигийн дэлийн хойд	447.17	1				
53	Бага тооно	2219.93	7	1			
54	Их улаан өндөр	1037.07	2				
55	Хар өндөр	1515.63	1				
56	Гээгийн ус	676.29	2	1			
57	Муу шандны ам	1939.33	1	6			
58	Ухаа шовх	1347.76	3	2			
59	Дөрвөлжин	920.02	2				
60	Сайн шандны ам	2091.87	4				
61	Майхантын овоо, Өгөөмөр	4222.13	13			2	
62	Баярт	2440.93	2				
63	Хар чулуутын ам, Цагаан хөтөл	4554.11	5	8			
64	Билүүт-2	945.60					
65	Зуслан	698.07					
66	Зуслан, намаржаа	5709.98		8			
67	Тэргэнэ Оломын хөндий, Дарцагт	7127.73	4	9			
68	Зуслан, намаржаа	23300.46	4	44		10	
69	Хэрлэн гол, Ар хүйтний ам	8757.57	8	5			

70	Бугын хөндий	2510.64	10				
71	Бургастайн ам	5010.59	19				
72	Зүүн баян булгийн ам	6534.55	16	1			
73	Ханзат уул	4258.44	6				
74	Ягаан	4588.32	7				
75	Баян булгийн ам	6536.97	27				
76	Барын яст	2219.22	4				
77	Тэмээн чулуут	3628.03	9				
78	Хөтөл үзүүр	8073.25	14				
79	Ар хүйтэн	1499.99	5			1	
80	Бургалтайн ам	4708.70	7	1			
81	Тарвагатын ам	7770.07	22				
82	Бэрх	3234.96	3	4			
83	Ар нурамт	9671.95	19	1			
84	Байц	11756.66	16				
85	Хөшигийн ам	4702.74	8	1			
86	Баянханы нуруу, Баян зүрх	2689.74					
Дүн		367477.81	484	343	2	21	2

Зураг-64. Бэлчээр ашиглалтын хэсгийн төлөвлөгөө зураг.



Хүснэгт-102. Бэлчээр ашиглалтын хэсгийн багтаамж.

Д/д	Хэсгийн		Талбай /га/	Га- ийн ургац /цн/	Тэжээлий н нөөц, цн	Хоньны жилд идэх өвс /цн/	Багтаа мж /хонь толгой/
	Баг	Нэр					
1	Аварга	Аварга тосон	3698.93	2.85	10541.96	б	1756.99
2	Аварга	Билүүт-1	655.65	2.75	1803.03	б	300.51
3	Аварга	Хар тал	9362.04	2.73	25558.37	б	4259.73
4	Аварга	Баяны хар тал	7636.23	2.64	20159.66	б	3359.94
5	Аварга	Хойд хар тал	2912.60	2.40	6990.25	б	1165.04
